



АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ	2-3
НЭГ. ЗОРИЛГО	4
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ	4
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	5-33
3.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ	5-10
3.2. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	10-20
3.3. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	20-28
3.4. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ	28-33
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	34-51
4.1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	34-41
4.2. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	41-44
4.3. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	54-51
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	51-61
5.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ	51-54
5.2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТ	55-56
5.3. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН	56-58
5.4. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ	58-61
ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	61-70
6.1. “НОГООН БАЙГУУЛАМЖ (МОД ТАРИХ)” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	61-63
6.2. “ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	63-65
6.3. “ЦАХИМ ШИЛЖИЛТ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	65-70
ДОЛОО. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	71-74
7.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ	71-74



МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж танд болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын нийт хамт олонд Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын хамт олны өмнөөс болон өөрийн зүгээс мэндчилж байна.

Говьсүмбэр аймгийн хувьд 2023 онд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, эдийн засаг, бизнес, хувийн хэвшлийн салбарыг дэмжсэнээр ажлын байрыг нэмэгдүүлж, хотоос хөдөөд шилжин суурьших хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилго тавин ажиллалаа.

Үүний үр дүнд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 155315.9 мян.төг, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 8581.9 мян.төгрөгт хүрч, аймгийн хүн ам 18079 болж, өмнөх оноос 0.2 хувиар нэмэгдэж, татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо 752 болж өмнөх оноос 7.1 хувиар өссөн байна.

Эдийн засгийн өсөлтийг хангах чиглэлээр Жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 398.0 сая төгрөг, сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас 115.0 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 150.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгон, 108 ажлын байрыг шинээр бий болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь ядуурлын түвшинг 3.5 хувиар буурахад нөлөөлсөн.

Мөн Улаанбаатар Төмөр зам ХНН, Шивээ-Овоо ХК-ын нүүрсний уурхай болон уул уурхайн боловсруулалт, тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 50 аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах ажиллагааг өргөжүүлэн, татварын бодлогоор дэмжин ажилласны үр дүнд орон нутгийн орлогод 12.2 тэрбум төгрөг төвлөрүүлэн 19 хувиар нэмэгдүүлсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг бий болгосон.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 14 зорилтот 134 багц арга хэмжээг тусган хэрэгжүүлэн, давхардсан тоогоор 63849 иргэнийг хамруулсан байна. Нийгмийн салбарын хөрөнгө оруулалтын ажлуудыг үргэлжлүүлж, Боржигин чуулгын барилгыг 53 хувьтай, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн барилга 45 хувьтай, 3 дугаар цэцэрлэгийн барилга 70 хувьтай, 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөл 75 хувьтай баригдаж байгаа бөгөөд 2024 оны төсөвт 9.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлуулаад байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, хурдан шуурхай хүргэх ажлын хүрээнд Стандартчилал, хэмжил зүйн газар, Төрийн цахим үйлчилгээний хэлтсийг тус тус байгуулж, иргэд орон нутагтаа цахимаар 70, нийт 457 төрийн үйлчилгээг шуурхай авах боломж бүрдсэн.

Иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр нийт 62.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, БНСУ-ын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар аймгийн төвд Дулааны станц барих төсөл 27, Польш улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар Цэвэрлэх байгууламж барих төсөл 54 хувьтай тус тус хэрэгжиж байна. Үүнээс гадна дэд бүтэц, авто замын сүлжээг өргөтгөх, Шивээговь сумын төвийг улсын чанартай авто замтай холбох, аюулгүй байдлыг хангах зорилгоор аймаг, сумдын төвийн гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулах, нэгдсэн удирдлагын төвийг бий болгох “Ногоон бүс” төслийг эхлүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.



2023 оны Засгийн газрын зорилттой уялдуулан “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, ажлын байр, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, хуулийн хүрээнд шилжин ирж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулж, санхүүгийн болон газар, дэд бүтцийн бодлогоор дэмжин ажилласан.

Үүний үр дүнд Улаанбаатар хотоос 150 иргэн, өөр аймгаас 388 иргэн, нийт 538 иргэн шилжин ирж, 3 иргэнийг ипотекийн 3 хувийн зээлэнд хамруулж, 15 төрийн албан хаагчдад орон байр түрээслэхэд 28.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бол шилжин ирсэн 1 ААН-ийг хуулийн дагуу татварын хөнгөлөлтөд хамруулаад байна.

Үүнээс гадна “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд аймаг, орон нутгийн төдийгүй бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд ахиц гаргахад цаашид үр дүн, үр нөлөө үзүүлэхүйц дараах төслүүдийг эхлүүлж, 540 айлын орон сууц, “Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологийн парк байгуулах”, Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордод тулгуурлан нүүрсхимийн үйлдвэр болон эрчим хүчний төв байгуулах төслүүдийн ТЭЗҮ боловсруулах, холбогдох дээд шатны байгууллагуудад уламжлан шийдвэр гаргуулах, газар, дэд бүтцийн бодлогоор дэмжих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын зүгээс бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг орон нутагт удирдан зохион байгуулж, гүйцэтгэл, үр дүнг дараах байдлаар тооцлоо. Үүнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт – 96.83
- Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт – 94.12
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт – 90.61
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт – 90.32
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт –

Дээрх бодлогын баримт бичиг тусгагдсан зорилт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, төрийн байгууллагын гүйцэтгэл, үйл ажиллагааг сайжруулан, нээлттэй ил тод байдлыг хангаж ажилласны үр дүнд Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс хийгдсэн “Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа”-аар Говьсүмбэр аймаг нь өрсөлдөх чадвараараа 81 оноогоор улсын хэмжээнд 5 дугаарт, хүний хөгжлийн индексээр 0.753 оноогоор 4 дүгээрт тус тус эрэмбэлэгдэж байна.

Өрсөлдөх чадварын тайлангаас харахад засаглалын үзүүлэлтээр 2, дэд бүтцийн үзүүлэлтээр 3, бизнесийн үр ашиг 10, эдийн засгийн тамир тэнхээ 13 дугаарт тус тус эрэмбэлэгдэж, цаашид бизнесийн орчинг сайжруулж, эдийн засгийн хүчин чадлаа нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Иймд бид 2024 онд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг уялдуулан бүс, орон нутгийн хөгжлийг дэмжсэн томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах, инновацид суурилсан шинжлэх ухаан, технологийн төвийг бий болгох, тээвэр-логистик, уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд суурилсан бизнес, эдийн засгийн орчинг өргөжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын амжиргааг дээшлүүлэх, ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх зорилтыг тодорхойлон, бодлогын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

Аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжин хамтран ажиллаж байгаа та бүгдийн ажил хөдөлмөрт өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн,

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.СОДНОМ



НЭГ. ЗОРИЛГО

Говьсүмбэр аймгийн хэмжээнд төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг тооцох зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу арга, аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой, үр дүнтэй байхад анхааран жилийн төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хэрэгжилтийг ханган, холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж өгч ажилласан бөгөөд 2021 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзлээ.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/561 дугаартай “Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн хавсралт “Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан” –д үндэслэн 2023 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөнд дүгнэлт, зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг тусган төлөвлөж, нутгийн захиргааны байгууллагуудад зөвлөмж өгч, гүйцэтгэлийн үр дүнд хяналт тавин, үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарсан.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагааны баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилтийн тайланг хамруулан авч үзсэн. Үүнд:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тооцоход:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн биелэлтийг тооцоход:

- Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээг тооцоход:

- Байгууллагын ил тод байдал
- Шилэн дансны хөтлөлт
- Шударга байдлын түвшин
- Хэрэглэгчийн үнэлгээ

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг тооцоход:

- “Ногоон байгууламж (Мод тарих)” арга хэмжээний хэрэгжилт
- “Цахим шилжилт” арга хэмжээний хэрэгжилт
- “Хог хаягдлын менежмент” арга хэмжээний хэрэгжилт

Журамд заасны дагуу ерөнхий үнэлгээг тооцоход бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг 50 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээг 15 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээг 20 хувь, Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг 15 хувиар тус тус тооцлоо.



ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 106 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 193 заалтыг хяналтад авч 96.83 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна. Нэгдсэн дүнг хүснэгт.1-ээр харуулав.

Хүснэгт.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		193
Бүрэн хэрэгжсэн	100%	161
Хэрэгжих шатанд	70%	19
Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Х.Б	13
Хэрэгжилтийн дундаж		96.83%

Дээрх дүнг хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр ангилан авч үзвэл Монгол улсын 13 хуулийн 34 заалтыг 100 хувь, Улсын Их хурлын 4 тогтоолын 8 заалтыг 96.25 хувь, Улсын Их хурлын байнгын хорооны 17 тогтоолын 44 заалтыг 95.71 хувь, Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 11 заалтыг 100 хувь, Засгийн газрын 31 тогтоолын 41 заалтыг 98.24 хувь, Засгийн газрын хуралдааны 28 тэмдэглэлийн 42 заалтыг 93.41 хувь, Засгийн газрын 4 албан даалгаврын 6 заалтыг 100 хувь, Үндэсний аюулгүй байдлын 4 зөвлөмжийн 7 заалтыг 95.71 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийн дэлгэрэнгүйг хүснэгт.2-оор харуулав.

Хүснэгт.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй

Төрөл / үнэлгээ	Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	106	13	4	17	5	31	28	4	4
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	193	34	8	44	11	41	42	6	7
Бүрэн хэрэгжсэн, 100 %	161	31	7	36	11	32	32	6	6
Хэрэгжих шатанд, 70%	9	-	1	6	-	2	9	-	1
Хэрэгжилт хангалтгүй, 30%	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжээгүй, 0%	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, ХБ	13	3	-	2	-	7	1	-	-
Биелэлтийн дундаж, хувь	96.83	100	96.25	95.71	100	98.24	93.41	100	95.71



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 01/561 дугаартай албан тоотгоор ирүүлсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган, 2023 оны эхний хагас жилд улирал бүр, сүүлийн хагас жилд сар бүр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн www.newunelgee.gov.mn цахим мэдээллийн санд хэрэгжилтийг хугацаанд нь оруулан баталгаажуулж ажилласан.

2. Хэрэгжилт, үр дүнг тайлагнаж, холбогдох нутгийн захиргааны байгууллагуудад хугацаатай зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

3. 2023 онд нэмэлтээр нийт 24 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тухай бүр хяналтад авч, холбогдох нутгийн захиргааны байгууллагуудад хариуцуулан, хэрэгжилтийг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, эерэг үр нөлөөг тооцон ажиллах талаар нутгийн захиргааны байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр төлөвлөлтийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийн дагуу шууд хариуцан гүйцэтгэх 34 байгууллага, албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд холбогдох зүйл, заалтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусган биелэлтийг хангуулах, гүйцэтгэлийн үр дүнг тооцоход харгазах, шаардлагатай төсөв хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгах чиглэлээр зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад анхааран ажилласан.

5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хянан үзэж бүрэн хэрэгжсэн, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон 99 заалтыг хяналтаас хасуулахаар журмын дагуу саналаа хүргүүлсэн.

Хяналтад байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 193 заалтаас хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй дараах 13 заалт байна. Үүнд:

- Нийслэлийнхээс бусад Зөвлөлийн даргын бүрэн эрхийг тухайн бүсэд багтах аймгийн Засаг дарга нараас үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний томилсон аймгийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

- Аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газар баталж мөрдүүлнэ.

- Аймаг, нийслэлийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах бол Санхүүгийн зохицуулах хороонд хялбаршуулсан журмаар бүртгүүлэх бөгөөд үүнтэй холбоотой журмыг Хороо батална.

- Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх;

- Итпортлогч улсын хорио уээрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

- Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.



- Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

- Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

- “Бигом чойр” ХХК-ийн уурхайн үйл ажиллагааг цахилгаан эрчим хүчээр хангах асуудлыг судлан, шаардлагатай арга хэмжээ авахыг Говьсүмбэр аймгийн Засаг дарга Г.Батсуурь, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК (Г.Балжинням)-д;

- Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.

- Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. (Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах.

- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай.

- Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүсийг тогтоох, шинэчлэн боловсруулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.

Дээрх 13 шийдвэрийн 13 заалт 2023 оны 12 дугаар сард батлагдсан тул 2024 оны төлөвлөгөөнд тусган хугацаанд нь хэрэгжилтийг бүрэн хангаж, үр дүнг тайлагнах шаардлагатай.

3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn мэдээллийн системийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” цэсэнд байршсан 4 зорилт 17 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалтын дагуу зорилт, арга хэмжээг 94.12 хувьтай хэрэгжүүлсэн гэж үнэлэв.

Бодлогын зорилт, арга хэмжээг үнэлэхдээ тухайн зорилт, арга хэмжээний хүрээнд 2023 онд төлөвлөсөн арга хэмжээний хүрсэн түвшинг, зорилтот болон суурь түвшинтэй харьцуулан үнэлсэн бөгөөд үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх үүднээс аймгийн бодлогын зорилтын уялдаа, зохион байгуулсан арга хэмжээний бодит үр дүн, үр нөлөөг харьцуулан авч үзлээ.



Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийн жилийн эцсийн дүн

Үзүүлэлт		Нийт
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо		17
Үр дүнтэй	100%	10
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	6
	70%	1
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	-
	30%	-
Үр дүнгүй	0%	-
Хугацаа болоогүй	ХБ	-
Хэрэгжилтийн дундаж		94.12%

Нийт 17 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 10, гол үр дүн гарч эхэлсэн 6, хэрэгжих шатанд 1 арга хэмжээ байна.

16 арга хэмжээний хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн боловч бодит үр дүн, үр нөлөөг сайжруулах, 1 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ:

3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Дээрх арга хэмжээний хүрээнд зураг, төсвийг боловсруулсан боловч хөрөнгө санхүүжилт дутмаг, шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна. Тус арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэхээр 2024 оны орон нутгийн хөрөнгө оруулалтад 100.0 сая төгрөг тусган батлуулсан.

Гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай арга хэмжээ:

3.3.6.1. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ

5.1.4.1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.

6.2.13.1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2023 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу хэрэгжилт удааширсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлж ажилласны үр дүнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлсэн. Үүнд:

1. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх чиглэлээр жижиг, дунд үйлдвэрийн газар, Best сургалтын төв, Зээлийн батлан даалтын сан, ЖДҮГ-тай хамтран 6 удаагийн сургалт зохион байгуулж, 5 аж ахуйн нэгж, бичил, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл 97 иргэнийг хамруулав. Энэ нь МАА-н гаралтай түүхий эд бэлтгэгчдийг 100% хамруулсан байна. 2023 онд ЖДҮХСангаас зээл олгуулахаар 697.9 сая.төгрөгийн санхүүжилт бүхий 6 төслийг дэмжсэнээс "Очирмөнх Хайрхан" ХХК-ийн Мах махан бүтээгдэхүүн боловсруулах төсөл 98.0 сая төгрөг, "Педим инсайт повер" ХХК-ийн Төмс, хүнсний ногооны зоорьбарих төсөл 60.0 сая төгрөг, "Өрнөх Чойр Хоршоо" ХХК-ийн



Эрчимжсэн мал аж ахуйн төсөл 240.0 сая төгрөг буюу нийт 3 төсөлд 398.0 сая төгрөгийг ЖДҮХСангаас олгож, шинээр 10 ажлын байр бий болсон. ЖДҮХС-аас 2022, 2023 онд санхүүжилт авсан 6 аж ахуйн нэгжийг чадавхжуулах, зээлжих чадварыг сайжруулах үүднээс "Бүтээлч Сео" бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөрт хамруулав. Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангаас "Дэвжих таван эрдэнэ" хоршоонд хадлангийн тоног төхөөрөмж авахад 50.0 сая төгрөг, 1 иргэнд хог хаягдал дахин боловсруулах цехийн тоног төхөөрөмж авахад 65.0 сая төгрөгийг олгосон.

2. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн 2022 оны жилийн эцсийн тооллогоор доторлогоогүй нүхэн жорлонтой өрх 1336, сайжруулсан нүхэн жорлонтой өрх 445 бүртгэгдсэн. Аймгийн хэмжээнд 124 өрх, аж ахуйн нэгжийн нүхэн жорлонг сайжруулж, шаардлагад нийцүүлж, 13 байгууллага гадна хөрс бохирдуулж буй нүхэн жорлонг буулгасан. Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний 2023 оны зардлын 2.3 сая төгрөгний санхүүжилтээр "Жорлонгоо өөрчилъе" аян, өдөрлөгийг зохион байгуулж, 6 аж ахуйн нэгж, 320 иргэн хамрагдсан. Байгальд ээлтэй, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн техник, технологийн оновчтой шийдлийг сурталчилж, Эколос ХХК, Өнгө нэм ТББ, Пластик центр ХХК, Илчит сансар ХХК, Жавхланта ариунжих ХХК-тай хамтран ажиллаж, саарал ус ашиглагч төхөөрөмжийг 1 өрх, 2 аж ахуйн нэгж суурилуулсан. 2024 оны орон нутгийн төсөвт "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлэхээр 60.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 52.0 сая төгрөгийг тусган батлуулсан.




График.1. Сайжруулсан нүхэн жорлонгийн тоо

3. Аймгийн хэмжээнд Хоршоо хөгжүүлэх сангаас хүнсний үйлдвэрийн 1 төсөлд 80.0 сая төгрөг олгосон. ЖДҮХСангаас Мах боловсруулах 2, газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах 1 үйлдвэр, цехэд 400.0 сая төгрөг олгохоор төсөл сонгон шалгаруулалтыг хийж, зээл олгуулахаар холбогдох байгууллагуудад материалыг хүргүүлсэн. 2022 онд ЖДҮХСангийн зээлийн дэмжлэгт хамрагдсан 1 хоршоо үйл ажиллагаагаа 2023 онд эхлүүлэн, 5 ажлын байр шинээр бий болсон. Аймгийн хэмжээнд нийт 36 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж, 87 хүнийг ажлын байраар хангасан байна. Үүнээс хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 12 цехэд 31 хүн, мод, модон эдлэл, барилгын материалын чиглэлээр 4 үйлдвэр цехэд 11 хүн, хүнсний үйлдвэрлэлийн 13 үйлдвэр, цехэд 45 хүн, Уул уурхай болон тээвэр-логистик 13 ажлын байр нэмэгдэж, 112 хүн, Худалдаа, үйлдвэр үйлчилгээний салбарт сул ажлын байранд нийт 210 хүн, хүнс, худалдаа, хөнгөн, жижиг дунд үйлдвэр ахуйн үйлчилгээний салбарт нийт 648 хүн, Шивээ-Овоо ХХК 438 иргэн, Төмөр замын 14 ачиж буулгах талбайд 122 иргэн, Жонш баяжуулах "МСТТ" ХХК 29 иргэн, "Адил оч" ХХК 19 иргэн, Баян Нексус ХХК-ийн ган бөмбөлгийн үйлдвэрт 38 иргэн тус тус ажлын байраар хангагдсан байна. Сүмбэр үүлдрийн каракуль хонины тоо толгойг өсгөх, каракуль арьс бэлтгэх чиглэлээр 5 хүнийг ажлын байраар хангаж, 61 ш каракуль хурганы арьс бэлтгэн 3.390.0 мян.төгрөгний борлуулалт хийсэн. Сүмбэр сумын "Язгуур баялаг-нэхий" хоршоо хүчин чадлаа 40 хувиар нэмэгдүүлэн, шинээр 3 ажлын байрыг бий болгож, 3200 ш арьс, нэхийг боловсруулан зах зээлд нийлүүлсэн. Хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах чиглэлээр орон нутгийн өмчит 1 аж ахуйн нэгжид 39, бусад 14 ажлын байр байна.



4. “Осо Констракшн” ХХК-тай гэрээ байгуулан 40 айлын орон сууцны барилгын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. 40 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. Мөн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 3 дугаар багт 315 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн улсын төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна бохирын шугам, орон нутгийн 240.8 сая төгрөгөөр 6кв ЦДАШ, 2Х630 кВт-ын хаалттай дэд өртөөний ажлыг тус тус гүйцэтгэсэн. Сүмбэр сумын 3-р багийн нутаг дэвсгэрт 32 айлын тохилог амины орон сууцыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барихаар аймгийн Засаг даргын 2023 оны А/107 дугаар захирамжаар ажлын хэсгийг томилон төсөл сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаад байна. 2021 онд 315 болон 40 айлын орон сууц барих төсөлд сонгон шалгаруулалт зарлан гэрээ байгуулж, 2023 оны жилийн эцсийн байдлаар 40 айлын орон сууцны барилга 80 хувьтай, 315 айлын орон сууцны барилга 25 хувийн гүйцэтгэлтэй байна.



Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн түрээсээр ашиглуулж байгаа 22 орон сууц байна. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт ирж ажиллаж байгаа 15 төрийн албан хаагчид орон нутгийн төсвөөс 19.5 сая төгрөгийн орон сууцны түрээсийн дэмжлэг үзүүлсэн.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 67.7 хувьтай үнэлэгдэж байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 94.12 хувь болж өссөн байна. Харьцуулсан дүнг графикаар харуулав.




График.2. Бодлогын зорилт, арга хэмжээний дундаж хэрэгжилтийн харьцуулалт

3.3. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

“Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор батлан, 2023 оны 03 сарын 30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж хэрэгжүүлэн ажиллаж байна.



Тус тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/102 дугаар захирамжаар “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөө”-г батлан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийн, шууд хариуцан хэрэгжүүлэх байгууллагад зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан арга, аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2022 онд 87.93 хувь байсан бол 2023 онд **90.61** хувь болж өмнөх оноос 2.68 хувиар өссөн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг дэлгэрэнгүй байдлаар дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 4. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт

Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо		219	
Үр дүнтэй	100%	130	
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	26	
	70%	21	
	50%	7	
Эрчимжүүлэх шаардлагатай	30%	4	
	0%	-	
Үр дүнгүй	100>...>90	14	
	90>...>70	12	
	(Хүрсэн түвшин - Суурь түвшин) / (Зорилтот түвшин - Суурь түвшин) * 100	70>...>50	4
	50>...>30	-	
	30>...>0	1	
Хэрэгжилтийн дундаж		90.61%	

Хүний хөгжлийг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 14 багц арга хэмжээг авч хэрэгжүүлэн, нийт 134 арга хэмжээнд давхардсан тоогоор 63849 хүнийг хамруулж, 453.9 сая төгрөг зарцуулсан байна. Арга хэмжээний хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.



Хүснэгт.5.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлж буй зорилтот хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт

№	Арга хэмжээний нэр	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	Нийт хамрагдсан хүний тоо	Зарцуулсан төсөв, сая төг
1	Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ	7	7016	13.9
2	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээ	11	13452	65
3	Боловсролыг дэмжих арга хэмжээ	12	6882	24.5
4	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээ	6	885	6.2
5	Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээ	9	4137	47.8
6	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ	5	2467	20
7	“Эрүүл хүнс- Эрүүл Монгол хүн” арга хэмжээ	4	284	20
8	Хоршоо, ахуй үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээ	5	19 хоршоо	25
9	Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ	15	19551	20.6
10	Мэдээлэлийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ	15	1186	111.5
11	Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ	12	2544	35
12	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ	12	4209	9.5
13	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ	8	65	32.9
14	Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ	13	1171	22
Нийт		134	63849	453.9

Дээрх зорилтот хөтөлбөр, арга хэмжээг үр дүнтэй (дундаж хэрэгжилт 94.9 хувь) төлөвлөн хэрэгжүүлснээр иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх, чирэгдлийг бууруулах, иргэдийг мэдээ мэдээллээр хангахаас гадна нийгмийн бүлгүүдийн оролцоог тэгш хангах, нийгмийн хөгжлийн салбаруудын бодлогын уялдааг сайжруулж, иргэдийг соён гэгээрүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд эерэг нөлөөллийг үзүүлж байна.

Мөн дээрх хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжихэд нөлөө үзүүлэхүй, нийгмийг салбарын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх ач холбогдолтой байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг тооцох зорилгоор хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг авч үзэхэд 82.3 хувьтай байгаа нь бодлогын зорилт, арга хэмжээ эдийн засаг, нийгмийн салбарын өсөлтийг хангахуйц хэмжээнд хэрэгжиж байгааг харуулж байгаа хэдий ч цаашид шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахад чиглэсэн арга хэмжээг 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Хүснэгт.6.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он	2023 он		Хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	
	1	2	3	4	5	6
1	Коронавируст халдвар эрсдэлийн түвшин	Буурах түвшин	Бага	Бага	Бага	100
2	Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан иргэдийн тоо	тоо	30897	11000	30900	100
3	Хүн амын дундаж наслалт	жил	73.56 /2021/	74	73.8 /2022 он/	99.7
4	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	10.5	10.3	8.7	100
5	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	промилль	0	0	0	100
6	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд	хувь	99.8	100	99.7	99.7
7	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	61.0 / 3 ирлүүлгийн дундаж /	70	78.2	100
8	Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтанд хамрагсад	тоо	9500	7500	8000	100
9	Шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах хүүхэд	тоо	4832	2000	1086	54.3
10	Шүд, амны хөндийн эрүүлжүүлэлт	хувь	30	27	25	92.5
11	Тавт вакцины 3 дахь тунгийн хамралт	хувь	99.8	100	99.6	99.6
12	Улаан бурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралт	хувь	99.8	100	99.8	99.8
13	Нийтийн биеийн тамир, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлэх хамрагдалтыг нэмэгдүүлэх: ААНБ-н хамрагдалт Иргэдийн хамрагдалт	хувь тоо	43.9 2815	41.1 2465	36.1 2165	87.8
14	Иргэдэд үйлчлэх зориулалтын спорт заал	тоо	11	0	11	100
15	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт	Хувь	92.8	97	96.06	99.03
16	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	Хувь	100	100	100	100
17	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	100.0	100	100	100
18	Элсэлтий ерөнхий шалгалтын үнэлгээ	Байр	10	9	5	100
19	Боловсролын чанарын индекс	Хувь	0.715	0.720	37.04	
20	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	31.0	30	31	97.0
21	СӨБ-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт	Хувь	93.3	70.0	100	100
22	ЕБСургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт	Хувь	45.6	81.0	100	100
23	ЕБС-ийн бүлэг дүүргэлт	Хувь	28.9	30	29	100
24	Мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчид тоо	Тоо	565	300	541	100
25	Мэргэжлийн боловсролын төгсөгчдийн ажил эрхлэлт	Хувь	60	70	43.2	61.7
26	Шинжлэх ухаан, инновацийг дэмжих төсөл хөтөлбөр	Тоо	3	2	4	100
27	Монгол бичгийг албан хэргийн түвшинд хэрэглэж эхэлсэн байгууллага	Тоо	0	12	24	100



28	Нийгмийн халамжийн сангаас үйлчилгээ авсан хүн /давхардахгүй/	Тоо	1317	1100	2137	100
29	Хөдөлмөрийн дутуу ашиглалт	Хувь	7.7 /2022 оны 03 дугаар улирал/	7.8	3.1	100
30	Бий болсон байнгын ажлын байр	Тоо	123	200	61	30.5
31	Түр ажлын байраар хангагдсан иргэн	Тоо	261	300	260	86.6
32	ХЭДСангийн эргэн төлөлт	Хувь	85.8	100	88.9	88.9
33	СХСангийн эргэн төлөлт	Хувь	34.4	80	100	100
34	ЖДҮДСангийн эргэн төлөлт	Хувь	50.1	98	76.2	77.7
35	ХЭДСангаас олгосон зээлийн үр дүнд бий болсон ажлын байр	Тоо	68	50	61	100
36	СХСангаас олгосон зээлийн үр дүнд бий болсон ажлын байр	Тоо	22	12	6	50
37	Гарааны бизнесийн зээлд хамрагдсан залуучууд	Тоо	2	12	2	16.6
38	Соёл урлагийн үйлчилгээний хүртээмж /ЭВЕНТ/	Хувь	51.0	49.0	100	100
39	Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	Хувь	27	20	35	100
40	10000 хүнд ногдох соёлын урлагийн байгууллагын суудлын тоо	Тоо	550	550	550	100
41	Шинээр бүтээсэн уран бүтээлийн тоо	Тоо	2	4	3	75
42	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	Хувь	1	25	1.2	4.8
43	Номын сангийн фонд	Тоо	11613	300	17330	100
44	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо	Тоо	413	359	357	99.4
45	Музейн үзмэрийн тоо	Тоо	1031	1017	1082	100
46	Музейгээр үйлчлүүлэгчийн тоо	Тоо	5284	1500	3214	100
47	Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	Хувь	73	73	48	65.7
48	Хүүхдийн хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	Тоо	72	73	19	100
49	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд	Тоо	31	29	19	100
50	15-34 насны залуучуудад соён гэгээрүүлэх нөлөөллийн үйлчилгээнд хамрагдалт	Хувь	43	38	50.2	100
51	Байгууллагуудын хаягжилт Монгол бичгээр	Хувь	90	80	95.5	100
52	Угийн бичиг хөтлөлтийн талаарх сургалтад хамрагдсан тоо	Иргэний тоо Өрхийн тоо	1801 46	74 25	997 910	100
53	Шилэн дансны үнэлгээ	Хувь	97.9	99.6	94.7	95.1
54	Цахим худалдан авах ажиллагааны түвшин	Хувь	100	100	100	100
55	Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум		125.6	155.3 /2022 он/	100
56	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	Сая.төг		8.4	8.6	100
57	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	Оноо	82.79	85	82.79 /2022 он/	97.4
58	Шинээр байгуулагдсан боловсруулах үйлдвэрийн тоо	Тоо	0	-	-	-
59	Нийт тариалсан талбай	Га	94.0	50	64	100
60	Хураан авсан төмс, хүнсний ногоо	Тн	424.6	310	439.28	100
61	Шинээр байгуулсан өвлийн хүлэмжийн тоо	Тоо	1	1	1	100
62	Хүнсний гол нэр төрлийн 9 бүтээгдэхүүний хангамжийн дундаж түвшин	Хувь	38.2	40	38.4	96



63	Боловсруулсан махны хэмжээ	Тн	51.0	55	56.8	100
64	Боловсруулсан сүүний хэмжээ	Тн	48.0	50	-	0
65	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн тоо	Тоо	58	43	32	74.4
66	Зээлийн дэмжлэгт хамрагдсан жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн тоо	Тоо	3	9	3	33.3
67	Шинээр бий болсон ажлын байрны тоо	Тоо	15	35	105	100
68	Шинээр ашиглалтанд орсон зоорь, агуулахын тоо	Тоо	1	1	2	100
69	Зоорь, агуулахаас зах зээлд нийлүүлж буй төмс, хүнсний ногоо, махны хэмжээ Үүнээс: Сумдын түвшинд Аймгийн түвшинд	Тн	60	250.1	47.37 тн	41.1
		Хувь	100.0	80	40	
		Хувь	100.0	90	50	
70	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцсэн талбай	Мян.га	5	30	6	20
71	Шинээр гарсан худаг	Тоо	4	2	3	100
72	Нэг малаас авах ашиг шим Цэвэр, эрлийз үнээний сүү /305 хоног/ Ноос Ноолуур	Тн	1.5 сүү	1.2	16.9 тонн сүү	98.2
		Кг	1.2 ноос	1.4	1.4 кг ноос	
		Кг	0.46 ноолуур	0.5	0.473 кг ноолуур	
73	Зохиомол хээлтүүлэгт орсон малын тоо	Толгой	385	400	-	0
74	Ангилалтад хамрагдсан малын тоо	Мян.тол	12.2	10	9.4	94.0
75	Каракуль хонины тоо	Толгой	1124	1851	992	53.5
76	Бэлтгэсэн хурганы арьс	Ш	208	200	377	100
77	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	Тоо	87	300	471	100
78	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний тоо	Тоо	8	2	6	100
79	Шинээр нэмэгдэх жуулчны бааз, отог, амралтын газрын тоо	Тоо	1	1	-	0
80	Олон улсын үзэсгэлэн арга хэмжээнд оролцсон тоо	Тоо	2	2	2	100
81	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	97.6	87.3	98.0	100
82	Шинээр баригдах дулааны станцын тоо	тоо	-	1	1	100
83	Төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэрт холбогдсон өрхийн тоо	Тоо	269	250	1132	100
84	Орон нутгийн чанартай хатуу хучилттай авто замын хэмжээ	Км	1.2	22.2	3.2	14.4
85	Явган хүний замын хэмжээ	Км	0.9	23.6	2.2	9.3
86	Дугуйн замын хэмжээ	Км	0.7	5.8	1.06	18.2
87	Шинээр байгуулагдах орон сууцны тоо	Айл	17	120	36	30
88	Шинээр бий болох барилгын материалын үйлдвэр, цехийн тоо	Тоо	1	1	-	0
89	Шинээр баригдах хаусын тоо	Тоо	1	10	40	100
90	Шинээр баригдах үерийн далан суваг, ус зайлуулах шугамын урт	Км	0	2	40метр	2
91	Төрийн байгууллагууд дотоод удирдлагын нэгдсэн системд холбогдсон байгууллагын тоо	Тоо	45	23	56	100
92	Интернет сүлжээнд холбогдсон багийн тоо	Тоо	6	9	10	100
93	Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас үзүүлж байгаа цахим үйлчилгээ	Цахим үйлчилгээ үзүүлж буй, байгууллагын тоо	18	18	15	91.6
		e-mongolia портал дээрх цахим үйлчилгээний тоо	457	200	457	
94	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	Хувь	100	100	100	100



95	Чанарын удирдлагын тогтолцоо, стандарт нэвтрүүлсэн төрийн байгууллагын тоо	Тоо	3	4	3	75
96	Мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалтанд хамрагдсан төрийн жинхэнэ албан хаагчдын тоо	Тоо	805	1000	2544	100
97	Аж ахуйн нэгж, иргэд, сайн дурын бүлэг, нөхөрлөлд чиглэсэн Гамшгаас хамгаалах сургалт	Хамрагдсан иргэний тоо Хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	3050 119	4000 90	1946 215	74.3
98	Гамшгаас хамгаалах иж бүрэн команд штабын сургалтын тоо	Тоо	3	-	3	100
99	Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн гамшиг, гал түймэр, аюулт үзэгдлийн тоо	Тоо	Гал-27 Гамшиг-59	50-иас бага	Гал-22 Гамшиг-24	100
100	Гэмт хэргийн илрүүлэлт	Хувь	56.6	58	70	100
101	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Хувь	18.7	14	15.9	86.5
102	Хохирол нөхөн төлүүлэлтийн хувь	Хувь	48.6	55	23	41.8
103	Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн тоо	Тоо	0	0	0	100
104	Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах гэмт хэргийн тоо	Тоо	0	0	0	100
105	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших гэмт хэргийн тоо	Тоо	0	0	0	100
106	Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийн тоо	Тоо	0	0	0	100
107	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Тоо	0	0	0	100
108	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг	Тоо	2	18	21	83.4
109	Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд /0-17 нас/	Тоо	12	7	19	36.8
110	Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо	Тоо	13	18	27	50
111	Малын хулгайн гэмт хэргийн тоо	Тоо	9	9	1	100
112	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо	Тоо	44	59	59	100
113	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудасны биелэлтийн хувийг нэмэгдүүлнэ	Хувь	55.2	54.9	65	100
114	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний гүйцэтгэл	Хувь	100	90.0	100	100
115	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалт	Сая.төг	296.9	Өмнөх оноос өссөн байна	390.0+	100
116	“Оюутан цэрэг” сургалтад хамрагдах суралцагчид	Тоо	0	42	8	19.04
117	Хашиж хамгаалсан, булаг шандын тоо	Тоо	1	1	1	100
118	Стандартын шаардлага хангасан жорлонгийн тоо	Тоо	36	15	564	100
119	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хэмжээ	Хувь	48	49	49	100
120	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	85.8	72	85	100
121	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	Хувь	37	43	22.0	51.1
122	Биотехникийн арга хэмжээний тоо	Тоо	5	4	5	100
123	Эрүүл ахуйн бүс тогтоосон эх үүсвэрийн тоо	тоо	4	4	9	100
124	Хог хаягдал цэвэрлэсэн талбайн хэмжээ	Га	12.3	10	12.8	100



125	Нөхөн сэргээсэн талбай /уул уурхай/	Га	8.9	5	5.8	100
126	Сумын төвийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжсэн сумын төвийн тоо	Тоо	0	1	1	100
127	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	72.6	56.9	49.02	86,1
128	Шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн тоо	Тоо	0	1	1	100
129	Гудамж гэрэлтүүлгийн тоо	Тоо	262	1002	296	29,4
130	Интернетийн үйлчилгээнд холбогдсон өрхийн тоо	Тоо	2198	100	1287	100
Дундаж хувь						82.3

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2023 оны 01/561 дугаартай албан бичгээр ирүүлсэн тайлан, дүгнэлт, зөвлөмжийн дагуу “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. Баянтал сумын спорт залны өргөтгөлийн зураг, төсвийг “Жаргалант хийц” ХХК-аар боловсруулан, 2024 онд аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлыг эхлүүлэхээр 700.0 сая төгрөгийг батлуулаад байна. Мөн Баянтал сумын Соёл, спортын цогцолборын барилгын зураг төслийг боловсруулах ажлыг “Ориент плюс” ХХК гүйцэтгэж, зураг төсвийг хянуулж, батлуулах шатанд байна. Гүйцэтгэл 90 хувьтай. Аймгийн 2024 оны зураг төсвийн зардалд Шивээговь сумын Соёлын төвийн барилгын холболтын зураг төсвийг хийлгэхээр аймгийн ОНХСанд 35.0 сая төгрөг тусган батлуулсан.

2. 2017 онд орон нутгийн төсвийн 16,8 сая төгрөгийн хөрөнгөөр “Цээнтэй Ателиер ХХК-тай гэрээ байгуулан зураг, төсвийг боловсруулан батлуулсан. 2024 оны барилгын ажлыг эхлүүлэхээр улсын төсөвт 3.7 тэрбум төгрөгийн төсөв тусган батлуулаад байна.

3. Шивээговь сумын 320 хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажлыг Говийн өгөөж ХХК гүйцэтгэн, барилгын ажил 45 хувьтай байна. Барилгын гадна инженерийн бохирын шугам, цахилгааны шугамыг татсан, санхүүжилтийн үлдэгдэл 2.78 тэрбум төгрөгийг 2024 оны улсын төсөвт тусган шийдвэрлэсэн. Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилгыг төсөвт өртөг 12.9 тэрбум, үүнээс 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилт 2024 оны улсын төсвийн хөрөнгөд тусган батлагдсан. Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн 320 хүүхдийн сургуулийн төсөвт өртөг 7.8 тэрбум, үүнээс 2.3 тэрбум төгрөгийн төсөв 2024 оны улсын төсөвт тусган батлагдсан.

4. Ахмадын өргөөний барилгыг шинээр барих ажлын зураг, төсвийг “Аслаан” ХХК-аар гүйцэтгүүлж, хүлээн авсан. 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлыг эхлүүлэхээр 2,662.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөс 1.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Мөн Шивээговь сумын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлын 6.0 сая төгрөгөөр ахмадын хороо, ХБИ-ийг дэмжих төвд тус бүрт нь телевизор болон зөөврийн өсгөгчийг авч өгсөн.

5. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлсэн. 2023 онд 25 албан бус хөдөлмөр эрхлэгчийг мэдээллийн санд бүртгэсэн. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажиллаж буй салбараар нь авч үзвэл мал аж ахуйн салбарт 7, уул уурхайн салбарт 2, нүүрс, жонш ачиж буулгах талбайд 16 иргэн ажиллаж байна. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэх, хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж 30 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан. Зөрчил илэрсэн аж ахуйн нэгж байгууллага байхгүй. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд өссөн дүнгээр нийт 69 албан бус хөдөлмөр эрхлэгч бүртгэлтэй байна.



6. Аймгийн хэмжээнд уул уурхайн олборлолтоор 1, бүтээгдэхүүн тээвэрлэлт, боловсруулалтын чиглэлээр 60, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн чиглэлээр 1, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр 4 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. 2023 онд Улаанбаатар төмөр замын Чойр өртөөг түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ачаа тээвэрлэлт, уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, боловсруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 аж ахуйн нэгжтэй уулзалт зохион байгуулан, 24 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Шивээ-Овоогийн ордыг түшиглэн нүүрс химийн болон, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгох чиглэлийн төсөл, хөтөлбөрийг бодлогоор дэмжин хамтран ажиллаж байна. Одоогоор ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байна. Сүмбэр суманд даацын блокны 1, хөнгөн блокны 2 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Даацын блокны үйлдвэрт Хаан банкнаас ногоон зээл олгосон. Тус үйлдвэрлэлийг эрхэлдэг Эрин зууны холбоос ХХК явган замын хавтан, авто замын бордюр үйлдвэрлэж байна. И-Эс- Би Солар Энержи ХХК-ийн 50мВт нарны цахилгаан станц ажиллаж, эрчим хүчээ төвийн шугаманд нийлүүлж байна. Мөн Сан Степп ХХК 50мВт-ын нарны цахилгаан станц байгуулах ажлын хөрөнгө оруулалтыг эхлүүлж, нарны станц суурилуулах ажлыг гүйцэтгэж, 2024 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэхээр байна. Сүмбэр сумын 4 дүгээр багийн Эмээлийн хондоос Дэрсэн ус хүртэлх 52 га газрыг” Ю-Пи-Си Чойр лэнд холдингс” ХХК-д сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар 25 жилийн хугацаатай ашиглуулахаар шилжүүлэн олгосон.

7. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж буй 50 ААНБ-тай уулзалт зохион байгуулж, 24 аж ахуйн нэгжтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Гэрээний хүрээнд тогтсон маршрутын дагуу тээвэр хийх, олон салаа зам гаргахгүй байх, авто замыг сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, тэмдэг тэмдэглэгээ хийлгэх, нэгдсэн зохион байгуулалтад орж хамтран ажиллах асуудлуудыг тусган хэрэгжүүлж байна. Мөн ачилт буулгалтын талбай эзэмшигч 4 аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн талбайд 6680 мод, 3 Аж ахуйн нэгж Сүмбэр сумын нийтийн эзэмшлийн талбайд 740 мод, нийт 7420 мод тарьсан. Сүмбэр суманд 1, Баянтал суманд 1 аж ахуйн нэгж байгууллага тоосжилтоос сэргийлсэн хашаа барьсан. Хууль зөрчсөн аж ахуйн нэгж байхгүй байна. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлттэй холбоотой автозамыг хариуцан хяналт тавих, хяналтын пост ажиллуулах зорилгоор сонгон шалгаруулалт зарлаж, одоогоор 1 аж ахуйн нэгжээс санал ирсэнийг судалж байна.

8. Улсын үзэсгэлэн худалдаанд 5 /Хийлэн брэнд ХХК, Сүмбэр хонь ЦСҮТ, Эхэн сүвэйн булаг хоршоо, Эко-тансаг гашуун хоршоо, Тэвшийн хажуу ус хоршоо/ аж ахуйн нэгж оролцож, 2 /Хийлэн брэнд ХХК, Эхэн сүвэйн булаг хоршоо/ аж ахуйн нэгж шагналт байранд шалгарсан. 2023 оны 11 дүгээр сарын 24-27 өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, мах сүүний үйлдвэртэй танилцах зорилгоор 45 малчин, бизнес эрхлэгчийн төлөөллийг туршлага судлуулсан. Тус арга хэмжээнд орон нутгийн хөгжил сангаас 10.0 сая төгрөг зарцуулсан.

9. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 119.5 сая төгрөгийн өртөг бүхий, 120 ш оёдлын машин, 2 ш товч хадах, бөхөлгөөний машин -2, уурын индүү 5 тус тус хүлээн авч төсөл сонгон шалгаруулалтаар 35 иргэнд оёдлын машин олгосон. Мөн 30.0 сая төгрөгийн өртөг бүхий 6*2 харьцаатай, 120м² талбайтай 5 ширхэг хүлэмж, 2 мөрт нарийн ногооны гар үрлэгч 2 ширхэгийг аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, газар тариалан эрхлэгч 5 иргэнд олгосон.



10. 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 385.5 сая төгрөгийн хөрөнгөөр “Шивээговь сумын халаалтын зуухыг 4.0 мВт-аар өргөтгөх” ажлыг Илчит Сансар ХХК-иар гүйцэтгүүлэн 2023 онд ашиглалтад хүлээн авсан. Мөн Ус-Ду ОНӨААТҮГ 268.0 сая төгрөг, Талын Илч ОНӨҮГ 200.0 мянган төгрөг, Илчлэг Шивээ ОНӨААТҮГ 34.5 сая төгрөгийн урсгал засвар хийсэн. Аймгийн ОНХСангийн 102.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 сумыг ус, дулаанаар хангадаг ОНӨААТҮГ газарт нэмэлт тэжээлийн генератораар хангасан.

11. Аймаг сумдын төв, хөдөөгийн 10 багаас 4 баг 4G, 6 баг 3G сүлжээнд холбогдсон. 1, 2, 3 дугаар багийн хэмжээд нийт 1287 өрх IPTV гурвалсан үйлчилгээнд холбогдсон. Шивээговь сумын хэмжээнд хөдөөгийн 2 дугаар /Бэлт/ багийн хязгаарын цэг сумын төвөөс 35 км хүртэлх зайтай байдаг тул 155 малчид интернэт сүлжээнд холбогдсон. Баянтал сум Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн Мобикомын өндөр хурдны интернеттэй холбогдсон бөгөөд хязгааргүй интернет, суурин утас, VOO 97 телевизийн суваг үзэх үндэсний оператор Мобиком ХХК-ны гурвалсан үйлчилгээнтэй VOO үйлчилгээг 34 өрхөд нэвтрүүлээд байна.

12. Орон нутгийн төсвийн 364.9 сая төгрөгөөр “Цагаан толгойн нуур” ХХК-тай гэрээ байгуулан Татварын хэлтэс, Аймгийн ЗДТГ-ын 2,3 дугаар давхрын хэсэгчилсэн засвар, БОАЖГ-ын нэгдүгээр давхар, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн урлаг, спорт заалны дээвэр засварын ажлуудыг гүйцэтгүүлж байна. Засварын ажлын гүйцэтгэл 95 хувьтай. Шинээр байгуулагдсан Стандарт хэмжил зүйн хэлтэс, Цахим хөгжлийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ойн анги, Сав газрын захиргаа, Насан туршийн боловсролын төвийг орон нутгийн өмчийн байраар хангасан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах арга хэмжээнүүд нь үр дүнгүй хэрэгжсэн, эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

2.5.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, 1000-аас доошгүй иргэдийг байнгын, 1200-аас доошгүй иргэдийг түр ажлын байраар хангана.

3.3.1.2 Тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих. Байгалийн хадлан бэлтгэж, аймаг, сумдын аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

3.3.4 Каракуль хонины тоо толгойг өсгөж, аймгийн брэнд болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.5.2. Аймгийн төвд дулааны станц барьж, сумдын төвийн уурын зуухыг өргөтгөн, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.

3.5.3.5 Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах шинэ техник технологи нэвтрүүлнэ.

3.6.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто үйлчилгээний төв байгуулна.

3.6.6. Ерөнхий зориулалтын нисэх буудлын газрын асуудлыг шийдвэрлэж, хамгаалалтад авах.

4.3.11.13 Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулна.

4.3.13.17 Хүнсний аюулгүй байдлын лабораторийн үйл ажиллагааг сайжруулж, шинжилгээнд хамруулсан бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлнэ.

7.1.7. Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

7.1.8. 1000 айлын орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын бодлогоор дэмжинэ.

7.1.8.17 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

7.1.14.31 Аймаг, төвлөрсөн хогийн цэгийн ашиглалтыг сайжруулж, дэвшилтэд техник технологээр хангах



- 7.1.14.32 Туурь болон хур хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар цэвэрлэнэ.
7.1.15.37 Аймаг, сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийнэ.

3.4. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт:

“Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө”-г аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 22–ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлан 2023 оны 03 дугаар сарын 30-ны 06 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан хэрэгжүүлсэн.

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулж, 2023 онд 7 зорилтын 176 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж шууд хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж өгч ажилласны үр дүнд төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 90.35 хувьтай ханган ажилласан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хүснэгтээр харуулав.

Хүснэгт.7. “Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт

Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо		176
Үр дүнтэй	100%	104
	90%	20
Тодорхой үр дүнд хүрсэн	70%	15
	50%	7
Эрчимжүүлэх шаардлагатай	30%	4
Үр дүнгүй	0%	-
	100>...>90	13
	90>...>70	13
(Хүрсэн түвшин - Суурь түвшин) / (Зорилтот түвшин - Суурь түвшин) * 100	70>...>50	2
	50>...>30	1
	30>...>0	-
Хэрэгжилтийн дундаж, хувь		90.32



“Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын ажлын зураг төсвийг ОНХСангийн 14.2 сая төгрөгөөр “Эм эм архитектур” ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авсан. Сүмбэр сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн санд 585.0 сая төгрөгийг тусган баталсан. Сүмбэр сумын 1-р сургуулийн гадна фасад, спорт заалны их засварын зураг төсвийг ОНХСангийн 8 сая төгрөгөөр Баярмега сервис ХХК-аар гүйцэтгүүлэн хүлээн авсан. Тус ажлыг хэрэгжүүлэхээр 2024 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн санд 635.0 сая төгрөг тусган баталсан. 5 дугаар сургуулийн дээвэр засварыг аймгийн ОНХСангийн 222.0 сая төгрөгөөр Луужин консалтинг ХХК засварласан. Баянтал сумын 4 сургуулийн урлаг, спорт залны дээвэр засварын ажлыг аймгийн ОНХСангийн 364.4 сая төгрөгөөр, ариун цэврийн өрөөний засварыг сумын ОНХСангийн 26.6 төгрөгөөр Цагаан толгойн нуур ХХК тус тус гүйцэтгэсэн.

2. Аймгийн хэмжээнд хадлангийн 3 салаа, 3 иргэн орон нутагт болон Дорнод, Хэнтий, Төв аймгийн зарим сумдад хадланд гарч 406 тн өвс бэлтгэсэн байна. Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуультай хамтран Сүмбэр сумын 6 дугаар багийн нутагт байрлах Уул худгийн атаршсан газрын хөрсний шинжилгээг хийлгэж "газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой" гэсэн дүгнэлт гарсан. Дээрх дүгнэлтийг үндэслэн 7.2 мян.га газрыг тариалангийн бүс нутгаар тогтоох саналыг аймаг, сумдын ИТХ-аар хэлэлцүүлж, ХХААХҮЯ-нд 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 02/67 тоот албан бичгээр хүргүүлсэн. Одоогоор Засгийн газрын шийдвэр гарахыг хүлээж байна. Аймгийн хэмжээнд нийт газар тариалангийн зориулалтаар ашиглаж буй эргэлтийн талбай 452.02 га байгаагаас 2023 онд 64.0 га газарт тариалалт хийж 519 тн төмс, хүнсний ногоо хураан авсан. Мөн 11.9 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 104 тн ургац хураан авсан.

3. Сүмбэр сумын 1 дүгээр багт дахин төлөвлөлтийн ажлыг хэрэгжүүлэхээр Багш нарын байрны оршин суугчидтай 2021.03.11-ний өдөр уулзалтыг зохион байгуулж, иргэдээс хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. Нийт 28 айл өрхөөс 11 өрх дэмжсэн саналыг өгсөн. Зураг төслийн “Жаргалант хийц” ХХК-тай гэрээ байгуулан 18.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр зураг төслийг гүйцэтгүүлж, 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилга, хот байгуулалтын яамтай хамтран “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль”-ийн үнэлгээг хэрэгжүүлж буй зөвлөх баг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Говьсүмбэр аймагт уулзалт хийж, төсөл хөтөлбөрийн гадна инженерийн шугам сүлжээний бэлтгэл ажил, инженерийн дэд бүтэцийн асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэх, судалгаа шинжилгээний ажлыг нарийвчлан гаргах, дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг асуудлыг тодотгосон.

4. Хөмөлтэйн гүүрний барилга, угсралтын ажлын зураг төсвийг “Тарвичин бүлэн” ХХК нь 2021 онд зураг төсвийг барилгын хөгжлийг төвөөр 8,788,4 сая төгрөгийн төсөвтэй батлуулж, хүлээлгэн өгсөн. 2024 онд Чойр-Мандалговь чиглэлийн авто замын ажлыг эхлүүлэхээр Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт баригдах ажлын санхүүжилт 7.99 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган батлуулсан.

5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Авто үйлчилгээний төв барих ажилд “Ариг бэхи шанд” ХХК шалгарч, ЗТХЯамтай 2023 оны 06 сарын 09-ны өдөр гэрээ байгуулаад байна. Аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 19-ний А/355 дугаар захирамжаар Автотээврийн үндэсний төв ТӨААТҮГ Говьсүмбэр аймаг дахь салбарт олгосон 2 га газарт Авто үйлчилгээний төв барихаар зураг, төсвийг боловсруулсан.







6. 2023 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгөөр Баяр Мега ХХК “Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв”-ийн зураг төсвийг боловсруулан хүлээлгэн өгсөн.

7. Чойр хотын захирагчийн алба байгуулахаар байгууллагын дүрэм, бүтэц орон тоог аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2021 онд баталсан. 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Захирагчийн ажлын албыг Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулан, үйл ажиллагааг эхлүүлэхээр Сүмбэр сумын төсөвт 60.0 сая.төгрөг тусган батлуулсан.


Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласнаар дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. Хүн амын дундаж наслалт 73.8 болж өмнөх оноос 0.2- оор нэмэгдэж, хүний хөгжлийн индекс 73.9-өөс 75.3 болж улсын хэмжээнд 5 дугаарт эрэмбэлэгдэж байна. Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр нөлөө дээшилж, ажилгүйдлийн түвшин 2021 онд 12.7 хувьтай байсан бол 2022 онд 5.5, 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 2 хувь болон буурсан.







Эрүүл мэндийн салбарын үзүүлэлтийг авч үзэхэд сүүлийн 16 жилийн хугацаанд эхийн эндэгдэл гараагүй, хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 9.5 байгаа нь өмнөх оноос 1 промилоор буурсан байна. 10000 хүн амд вируст гепатитын өвчлөл 1.7 байгаа нь өмнөх оноос 0.5 промилоор буурсан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд товлотт вакцинжуулалтад нийт хүүхдийн 99.6 хувийг хамруулж, хорт хавдрын эрт илрүүлэгт зорилтот бүлгийн хүн амыг 78.2 хувь хамруулсан боловч артерийн даралт ихсэх болон чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт хамрагдалтын хувь буурсан байна.





2. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 100%, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 96.06 хувьд хүрч, улсад 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Сургалтын чанарын үнэлгээгээр СӨБ-ын гүйцэтгэлийн үнэлгээ 87.8, ЕБС-ын дундаж 72.5% үнэлэгдсэн нь улсын хэмжээнд 6 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж үнэлгээ дээшилж, 2022 онд 528 оноо, 2023 онд 523 оноогоор улсын дундажаас дээгүүр амжилт гаргасан, улсад 6 дугаарт эрэмбэлэгдэж байна.



3. Дотоодын нийт бүтээгдэхүүн 155.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 10.4 хувиар, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 69.4 тэрбум төгрөг болж өмнөх жилээс 6.8 хувиар, 1 хүн ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 11.6 хувиар тус тус өссөн байна.




4. Татвар төлөгчдийн тоо 752 болж өмнөх оноос 7.2 хувиар нэмэгдсэн. Үүний үр дүнд 2021-2023 онд улсын төсвийн орлогын биелэлт 2021 онд 1,458.2 сая. төг буюу 115.1 хувь, 2022 онд 2,733.5 сая. төг буюу 153.3 хувь, 2023 онд 2,309.6 сая. төг буюу 130.6 хувь, орон нутгийн төсвийн орлого 2021 онд 9,992.9 сая. төг буюу 150.5 хувь, 2022 онд 9,444.9 сая. төг буюу 104.0 хувь, 2023 онд 12 192.8 сая. төг буюу 119.0 хувийн биелэлттэй байна.







5. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үр дүнг авч үзэхэд урьдчилсан дүнгээр 450.1 мян.толгой мал тоологдож өмнөх оноос 3 хувиар буурсан, хураан авсан төмс, хүнсний ногоо 0.272 мян.тн байгаа нь өмнөх оноос 9.2 хувиар өссөн байна.



6. 2023 оны байдлаар төв суурин газарт амьдарч байгаа 3100 өрхөөс 3038 өрх буюу 98 хувь нь төвлөрсөн цахилгаан хангамжид, 1645 өрх буюу 53.06 хувь нь төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон байна.




7. Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 2021 онд 138.4 сая.төг, 2022 онд 229.4 сая.төг, 2023 онд 230.0 сая. төг болж 2021 онтой харьцуулахад 39.8 хувиар өссөн байна. Бүх нийтээр мод тарих өдөр”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний





хүрээнд 2021 онд 16559, 2022 онд 54251, 2023 онд 52474, нийт 123284 мод, бут тарьж, дундаж ургалт 82.3 хувьтай байна.

8. Гэмт хэргийн гаралт 2021 онд 135, 2022 онд 143 бүртгэгдсэн бол 2023 онд 139 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 4-өөр буюу 2.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хүнд гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 4-өөр буюу 18.2 хувь буурч, хөнгөн гэмт хэрэг 121 бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй адил, гэмт хэргийн илрүүлэлт 70.0 хувьд хүрсэн нь өмнөх оноос 4.5 хувиар өссөн байна.




9. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 11 төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 25.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгуулан шийдвэрлүүлсэн байна.

Хүснэгт.8. Санхүүжилтийг шийдвэрлүүлсэн төслийн жагсаалт


№	Төслийн нэр	2024 оны төсөвт тусгагдсан, тэрбум.төг
1	Усан бассейн бүхий спорт цогцолбор	3.7
2	Шивээговь сумын 320 хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн барилга	2.78
3	Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилга	3.9
4	5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн нэмэлт санхүүжилт	0.442
5	Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэмэлт санхүүжилт	0.7
6	Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 120 хүүхдийн цэцэрлэгийн барилга	1.5
7	Ахмадын өргөөний барилга	1.3
8	Боржигин чуулгын барилга	2.2
9	Хүүхдийн ордон	2.5
10	Жижиг, дунд үйлдвэрлэлийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт	0.45
11	Дулааны станцын цахилгаан хангамж, инженерийн дэд бүтэц (Сүмбэр сумын инженерийн шугам сүлжээний 2 дугаар хэлхээ)	5.8
Нийт		25.272

10. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оноос 20.4 хувиар нэмэгдэж, 2023 онд нийт 14.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.





11. Улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хөшиг Уул” ХХК “Дуу бүжгийн боржигин чуулгын барилга”-ын ажлын нийт гүйцэтгэл 53 хувьтай, тухайн жилд төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100 хувьтай. Магадлалаар дахин хянагдсан нийт төсөвт өртөг 12,430.2 сая төгрөг, олгогдсон нийт санхүүжилт 6,008.1 сая төгрөг, 2024 оны төсөвт батлагдсан санхүүжилт 2.2 тэрбум төгрөг.




12. Чойр хотын

хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлж, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 сарын 07–ний өдрийн 03 дугаар тогтоолоор суурьшлын бүсийг 1294.89 га-аар нэмэгдүүлж, хөгжлийн бүсүүдийг тогтоолоо. Ерөнхий төлөвлөгөөний тодотголын ажлын гүйцэтгэл 90 хувьтай хийгдэж байгаа бөгөөд иргэдийн саналыг авах нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сүмбэр сумын 1, 2 дугаар багт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх ажлыг Жаргалант хийц ХХК гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

13. БНСУ-ын Эксим банкны хөрөнгө оруулалтаар 20 Гкал/ц хүчин чадалтай дулаан станц барих ажлыг эхлүүлж, 27 хувийн гүйцэтгэлтэй байна. Польш улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар аймгийн төвд цэвэрлэх байгууламж барих ажлыг эхлүүлж, ажлын гүйцэтгэл 54 хувьтай байна.



14. Сүмбэр сумын 3 дугаар багийн шинэ суурьшлын бүсийн Ханан, Гашуун, Тагтын гэр хороололд сумын ОНХСангийн 79.0 сая төгрөгөөр 130 гэрэлтүүлгийг шинээр суурилуулсан. Сүмбэр сумын 1 дүгээр багийн Худалдаачдын гудамжны тохижилтын ажлыг эхлүүлж, аймгийн ОНХСангийн 214.4 сая төгрөг, аймгийн авто замын сангийн 440 сая төгрөгөөр 0.36 км авто зам, улсын төсвийн 3,283.5 тэрбум төгрөгөөр 2.8 км авто зам, 2.85 км явган зам, улсын төсвөөр 45 гэрэлтүүлэг, аймгийн ОНХСангаар 82 гэрэлтүүлэг суурилуулсан.





15. 2023 онд орон нутгийн төсвийн 40.0 сая төгрөгөөр Сүмбэр суманд 18 камер, Баянтал суманд 14 камер шинээр суурилуулж, Шивээговь суманд 13 камерийг засварласан. Аймгийн хэмжээнд нийт 92 камер байгаагаас Сүмбэр суманд 60, Баянтал суманд 14, Шивээговь суманд 18 камер байна. Үүнээс Сүмбэр суманд байгаа 27 камерийн ашиглалтын хугацаа дууссан. Сүмбэр суманд “Ногоон бүс” төслийг эхлүүлсэн.

16. Цахилгаан эрчим хүчний хангалтыг сайжруулж, шинэ суурьшлын бүсэд 6 кВт-ын хүчин чадалтай 3000 м агаарын шугам шинээр татаж, 2022 онд 36 өрх, 2023 онд 130 өрх хэрэглэгчийг шинээр цахилгаан эрчим хүчинд холбосон. (Тэрэгтэд - 72, Бурхантын гэр хорооллолд 58 нийт 130 өрх.)

17. Баянтал суманд “Мал аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн парк” байгуулах төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Мон эксел ХХК хэрэгжүүлэхийг аймаг, сумын ИТХ-аар дэмжиж, Засгийн газраас тус төслийг хэрэгжүүлэх 15 жилийн зөвшөөрлийг олгосон.

18. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Арга бэх шанд ХХК-ийн “Авто тээврийн үйлчилгээний төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэхээр ЗТХЯ-аас гэрээ байгуулсан бөгөөд тус төслийг Авто тээврийн үндэсний төвд олгосон 2 га газар дээр хэрэгжүүлэхийг дэмжин хамтран ажиллаж байна.

Төлөвлөгөөнд туссан дараах арга хэмжээнүүдийн хэрэгжилт 30-аас 50 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд:

56. Сүмбэр хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөн, генетик нөөцийг зохистой ашиглана.

69. Дулааны станц болон Дулаан дамжуулах төвүүдийг гадна инженерийн шугам сүлжээнд холбож, 2-р хэлхээний шугам сүлжээг шинэчлэх ажлыг хийнэ.

75. Тусгай зориулалтын онгоц хөөрч буух газрын асуудлыг шийдвэрлэж, арчлалт хамгаалалтыг хийнэ.

81. Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

102. Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулна.

161. Аймаг, төвлөрсөн хогийн цэгийн ашиглалтыг сайжруулж, дэвшилтэд техник технологээр хангах

162. Туурь болон хур хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар цэвэрлэнэ.

70. Аймгийн төвд авто үйлчилгээний төв байгуулна.

86. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

151. 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

167. Аймаг, сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийнэ.

23. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн иргэдийг ажлын байраар хангаж, ядуурлыг бууруулна.

56. Сүмбэр үүлдрийн хурганы арьс бэлтгэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

6. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоог зохион байгуулна.



3.4.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг эдийн засаг, нийгмийн суурь үзүүлэлт дээр тулгуурлан аймгийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлж, 2023 оны жилийн эцсийн байдлаар эдийн засгийн хөгжлийн 22, нийгмийн хөгжлийн 24, нийт 46 шалгуур үзүүлэлтийг тооцон, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 91.81 хувь буюу 4.59 оноогоор үнэллээ.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг тооцохдоо дараах мэдээллийн эх сурвалжийг ашигласан. Үүнд:

- Аймгийн жилийн эцсийн статистик мэдээ, www.1212.mn
- Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
- Аймгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ
- e-job программ
- Нийгмийн даатгалын хэлтсийн статистик мэдээ
- Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан
- Газар тариалангийн нэгдсэн мэдээллийн сан
- Байгаль орчны мэдээллийн сан
- Цагдаагийн байгууллагын статистик мэдээ
- www.esis.edu.mn
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарын статистик мэдээ
- Бодлогын баримт бичгийн 2021, 2022, 2023 оны жилийн эцсийн тайлан

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг тооцон, нэгдсэн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт.9. Санхүүжилтийг шийдвэрлүүлсэн төслийн жагсаалт

Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо		41
Үр дүнтэй	100%	25
	100>...>90	8
	90>...>70	5
(Хүрсэн түвшин - Суурь түвшин) / (Зорилтот түвшин - Суурь түвшин) * 100	70>...>50	1
	50>...>30	1
	30>...>0	1
Дундаж хэрэгжилт		91.81

Үнэлгээнээс харахад 100 хувьтай хангасан 25, 90-99 хувьтай хангасан 8, 80-89 хувьтай хангасан 3, 70-79 хувьтай хангасан 2, 30-69 хувьтай 2, 0-29 хувьтай хангасан 1 шалгуур үзүүлэлт байна.

Аймгийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдээс Дотоодын нийт бүтээгдэхүүн, Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, Хүний хөгжлийн индекс, Жендерийн тэгш бус байдлын индекс зэрэг үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн мэдээлэл Үндэсний статистикийн хорооноос зарлаагүй байгаа тул үнэлгээнд оруулаагүй. Мөн манай аймаг үр тариа тариалдаггүй учир үнэлгээнд оруулаагүй болно.



Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батласан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 10. Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин				Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал, 2023 он		Эх сурвалж
		2020 он	2021 он	2022 он	2023 он			2023 он	Хувь	
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ										
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн /сая.төг/	124.5	139.2	155.3	125.6	2023 оны 7 дугаар сараас гарах тул хугацаа болоогүй байна.				Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn
2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ /Мян.төг/	7,028.3	7,698.79	8 581.9	8.4					Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn
3	Төсвийн орлого бүрдүүлэлт (сая.төг)	5520.4	19649.6	21566.8	19,141.6	24049.6	100	5	Аймгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ	
4	Төсвийн зардал /сая.төг/	16535.2	19371.2	19382.1	19,141.6	19107.3	100	5		
5	Төсвийн тэнцэл /сая.төг/	1376.80	4597.8	2541.0	1,100.00	4942.3	100	5		
6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	100	-	87.0	100.0	76.2	76.2	3.8	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн программ	
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	70.0	89.1	85.8	100.0	80.0	80.0	4.0	ХХҮГ-ын статистик мэдээлэл	
8	Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	67.8	30.9	100	100	100	100	5.0	Хоршоо хөгжүүлэх сангийн программ	
9	Ажилгүйдлийн түвшин /хувь/	10.0	12.1	5.5	7.8	2023 оны III улирлын байдлаар 2.0	100	5.0	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	
10	Ажиллах хүчний оролцооны хувь	60.5	65.7	51.9	63.0	2023 оны III улирлын байдлаар 52.5	83.3	4.2	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	
11	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	204	116	122	250.0	108	43.2	2.2	e-job цахим систем	
12	Хэрэглээний үнийн индекс	102.5	114.0	112.4	102.0	106.9	95.4	4.8	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	
13	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан	97.0	91.0	99.3	100.0	100	100	5.0	Нийгмийн даатгалын хэлтсийн статистик мэдээ	



14	иргэдийн нийт хүн амд эзлэх хувь																		Нийгмийн даатгалын хэлтсийн статистик мэдээ
15	Эдийн засгийн идэвхтэй хүн ам /ажиллах хүч/-ын нийгмийн даатгалд эзлэх хувь	52.5	58.5	65.1	53.0	67.0	100	5.0											Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан
16	Малын тоо /мян.толгой/	452.0	432.1	464.2	460.0	450.1 урьдчилсан байдлаар	97.8	4.9											Газар тариалангийн нэгдсэн мэдээллийн сан
17	Хураан авсан үр тариа /мян.тн/	-	-	-	-	-	-	-											Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан
18	Хураан авсан малын тэжээл, бусад таримал /мян.тн/	0.042	0.04	0.115	0.050	0.1	100	5.0											Газар тариалангийн нэгдсэн мэдээллийн сан
19	Хураан авсан хүнсний ногоо /мян.тн/	0.190	0.218	0.247	0.220	0.272	100	5.0											Татварын хэлтэст бүртгэлтэй ААНБ-ын тоо
20	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо	206	288	345	240.0	500	100	5.0											Байгаль орчны мэдээллийн сан
21	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	213	0.0	87	220.0	471	100	5.0											ГХБХБ-ын газрын тайлан, мэдээ
22	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	58.9	73.6	73.0	67.9	73.0	100	5.0											Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn
23	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	83.3	97.2	97.6	87.2	97.9	100	5.0											
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ																			
23	Хүн амын дундаж наслалт /тоо/	73.65	73.56	73.9	73.56	73.8	100	5.0											Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn 2023 оны үзүүлэлтээр
24	Хүний хөгжлийн индекс	0.753	0.739	0.753	0.722	Үндэсний статистикийн хорооноос мэдээллийг 2024 оны 6 дугаар сараас гаргах тул хугацаа болоогүй байна.												Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn	
25	Жендерийн тэгш бус байдлын индекс	0.297	0.337	0.345	1.00														
26	Бүртгэгдсэн гэмт хэрэг /тоо/	152	135	143	135.0	139	90	4.5											Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn
27	Иргэдэд учирсан хохирлын нөхөн	53.3	72.4	62.7	55.0	51.2	93.1	4.7											Цагдаагийн байгууллагын статистик мэдээ



	төлүүлэлтийн түвшин /хувь/								
28	Агаар дахь PM2.5 тоосонцорын жилийн дундаж /Мкг/м3/	0.019	0.011	0.022	-	0.014	100	5.0	Map.purpleair.com сайт
29	Агаар дахь PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж /М кг/м3/	-	-	0.026	-	0	100	5.0	Map.purpleair.com сайт
30	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	0.007	0.008	0.008	0.010	0.018	100	5.0	Байгаль орчны мэдээллийн сан
31	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	0.03	0.04	0.5	0.6	2.5	100	5.0	Байгаль орчны мэдээллийн сан
32	Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	74.0	75.0	76.8	80.6	79.0	98.0	4.9	Байгаль орчны мэдээллийн сан
33	100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	0	0	0	0	0	100	5	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
34	1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	11.7	2.1	10.5	10.3	9.5	100	5	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
35	10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл	0	0.5	3.1	0	1.7	0	0	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
36	Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	99.8	99.8	99.8	99.8	99.6	99.8	4.98	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
37	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	100.0	94.2	81.3	100.0	77.6	77.6	3.88	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
38	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	100.0	96.9	94.6	100.0	86.2	86.2	4.3	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
39	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	40.0	69.9	61	75.0	100	100	5.0	Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан 1313.mn
40	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /хувь/	98.1	91.4	92.8	98.8	96.06	97.2	4.9	www.esis.edu.mn
41	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин /хувь/	98.6	100	100.0	100.0	100	100	5.0	www.esis.edu.mn
42	Цэцэрлэгийн бүлгийн нэг	31.0	28.9	31	29	31	90	4.5	www.esis.edu.mn



	багшид ногдох хүүхдийн тоо								
43	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	31.5	27.8	28	29	29	100	5.0	www.esis.edu.mn
44	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	508.2	520	528	510.0	523	100	5.0	www.esis.edu.mn
45	Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо	2020 оноос хойш Батлан хамгаалах яамнаас манай аймагт Оюутан цэрэг сургалтад хамрагдах квот тогтоогоогүй болно			14	8	57.14	2.85	Батлан хамгаалахын сайдын 2023 оны А/96 дугаар тушаалын ковотын дагуу
46	Төрийн цахим үйлчилгээний тоо	54	387	457	84	457	100	5	e-mongolia, e-barimt, e-job программ
Дундаж үнэлгээ							91.81	4.59	

Эдийн засаг, нийгмийн дараах шалгуур үзүүлэлтүүд зорилтот түвшинд хүрээгүй байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь
 2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь
 3. Ажиллах хүчний оролцооны хувь
 4. Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо
 5. Хэрэглээний үнийн индекс
 6. Малын тоо, /мян.толгой/
 7. Бүртгэгдсэн гэмт хэргийн тооны бууралт
 8. Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин /хувь/
 9. Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь
 10. 10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл
 11. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь
 12. Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь
 13. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин /хувь/
 14. Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо
 15. Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо
- Иймд дээрх эдийн засаг, нийгмийн шалгуурыг хангах арга хэмжээ бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахад анхаарах шаардлагатай.



ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр дараах 20 сайдтай аймгийн Засаг дарга гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр тус бүр 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, тайланг хугацаанд нь холбогдох сайдуудад хүргүүлсэн.

2023 оны жилийн эцсийн байдлаар гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дундаж хэрэгжилтийг 94.7 хувиар дүгнэсэн нь өмнөх оноос 0.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт.11. Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Гэрээний нэр	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	
		2022 он	2023 он
1	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ	100	95.7
2	Монгол Улсын шадар сайд, Говьсүмбэр аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	95.2	96.0
3	Хууль зүйн сайдын аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээ	94.5	96.9
4	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд болон аймгийн Засаг даргын хооронд байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээ	99.0	95.6
5	Батлан хамгаалахын сайдын Говьсүмбэр аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээ	94.4	96.7
6	Засгийн газрын гишүүн, барилга, хот байгуулалтын сайд болон аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулах гэрээ	94.5	95.3
7	Зам, тээврийн сайд, аймгийн Засаг дарга нарын хамтын ажиллагааны гэрээ	90.3	90.0
8	Хүнс, хөдөө, аж ахуйн сайд, Говьсүмбэр аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	90.4	91.1
9	Боловсрол, шинжлэх ухааны яамны сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн Засаг даргын хооронд 2023 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээ	97.8	94.5
10	Эрчим хүчний сайд аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	93.3	92.3
11	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд болон аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	94.1	93.3
12	Эрүүл мэндийн сайд Говьсүмбэр аймгийн Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ	95.4	97.4
13	Хөдөлмөр нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	92.0	91.8
14	Монгол Улсын Сангийн сайд болон аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээ	97.8	95.7
15	Соёлын сайд Говьсүмбэр аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	96.0	95.6



16	Эдийн засаг, хөгжлийн сайд болон аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	96.6	97.8
17	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон аймгийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээ	96.7	93.9
18	Гадаад харилцааны сайд болон аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	99.0	95.3
19	Биеийн тамир спортын хорооны дарга болон Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	-	92.5
20	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээ	-	95.9
Үнэлгээний дундаж		95.3	94.7

Дээрх хүснэгтээс харахад Эдийн засаг, хөгжлийн сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт хамгийн өндөр буюу 97.8 хувь, Зам, тээврийн сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилт хамгийн бага буюу 90.0 хувьтай хэрэгжсэн байна.

Хамтран ажиллах гэрээний хүрээнд 2023 онд дараах яамдын сайд, дэд сайд болон холбогдох алба хаагч нар орон нутагт ажиллаж, гэрээнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд:

Барилга, хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний хүрээнд:

Аймгийн ОНХС-ийн 15 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Хорихын 75 айлын орон сууцны гадна дулааны шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажлыг “Ар төгөл “ ХХК нь 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 95.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянтал сумын 154 дүгээр байрны техникийн давхарын 550-600 м төв инженерийн шугам сүлжээг засварлах шинэчлэх ажлыг Такамаца ХХК-иар гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан.

Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар “Мөнх Зүмбэр” ХХК улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын Ганзам багийн 408 айл өрх, 70 аж ахуйн нэгж байгууллагыг бохирын төвлөрсөн бохирын шугамд холбох 120 м төв магистрал шугамын ажлыг 80 хувьтай гүйцэтгэж байна.

Сүмбэр сум 482м хэрэглээний халуун усны шугам, Шивээговь сум хэрэглээний халуун усны 250 м шугаманд урсгал засвар хийсэн.

Аймгийн ОНХСангийн 83.0 сая төгрөгөөр Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд 215м цэвэр усны шугам татах ажлыг “Такамаца” ХХК-тай гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Батлан хамгаалах яамны сайдтай байгуулсан гэрээний хүрээнд:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаал, шийдвэрийн бүртгэлээр 10 баримт бичгийг хүлээн авч бүртгэн, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хамтран зохион байгуулах хэрэгжүүлэх байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаа. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус 5 байгууллагын 195 албан хаагчийг хамруулж цэргийн үүргийн биелэлтэд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгууллаа. Энэ хүрээнд цэргийн бүртгэлд хамрагдаагүй, цэрэг татлагаас завсардсан 21 иргэнд хуулиа биелүүлэх талаар сануулга өгч, цэргийн батлахаа гээгдүүлсэн 19 иргэнд батлахыг нөхөн олголоо. Мөн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах үүргээ хугацаанд нь биелүүлээгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж 8 иргэний төлбөрийг барагдуулсан байна.

Гадаад харилцааны яамны сайдтай байгуулсан гэрээний хүрээнд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Жиангсу мужийн Үши хотын захирагчийн урилгаар найрсаг харилцаа тогтоох санамж бичгийн хүрээнд аймгийн Засаг дарга Г.Батсуурь тус хотод



2023 оны 03 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд айлчилсан. “Интоорын мод цэцэглэх олон улсын фестиваль”-д оролцсон тайланг Б/358 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Оросын холбооны улсын Эрхүү мужийн Ангорск хоттой найрсаг, хамтын ажиллагаа тогтоох санамж бичиг байгуулахаар 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн Б/219 тоот албан бичгээр Орос, Монгол хэл дээрх санамж бичгийн төслийг Гадаад харилцааны яамны Гэрээ эрх, зүйн газарт хүргүүлсэн бөгөөд тус газраас зөвшөөрөл олгосны дагуу 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ш.Билэггүмбэрэл санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан.

Засгийн газрын хэрэг Эрхлэх газрын даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийн хүрээнд:

ЗГХЭГ-аас өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шинэ маягтаар хүлээн авах талаар байгууллагын албан хаагчдад танилцуулж, өргөдөл, гомдол, санал хүсэлтийн талаар харилцан санал солилцсон. Өргөдөл, гомдлыг цахимаар хүлээн авах цэс аймгийн албан ёсны цахим хуудсанд /Govisumber.gov.mn/-д байршуулж, мөн иргэдийг сонсох нээлттэй утас 70543434 ажиллуулж байна. Иргэдийг сонсох 70543434 утсанд нийт 6 өргөдөл ирснийг 100% шийдвэрлэсэн. Бичгээр аймгийн Засаг даргад хандаж 91 өргөдлийг хүлээн авч бүртгэн, хяналт тавин ажиллаж байна. Нийт 91 өргөдөл ирснээс хугацаа болоогүй 19 өргөдөл, 72 өргөдөл 100% шийдвэрлэгдсэн байна.

Зам тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

Улсын төсвийн 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын төвийг улсын чанартай авто замтай холбох 6.9 км авто замын ажлыг “Даблю экс пи” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж, ажлын явц 17%-тай байна.

Баянтал сумыг улсын чанартай авто замтай холбох 3.1км авто зам барих ажлын зураг, төсвийг хийлгүүлэн, 2024 оны улсын төсөвт 2,336.60 төгрөг батлагдсан.

Шивээговь сумын төвийг улсын чанартай авто замтай холбох 6.9 км авто замын ажил, “Сүмбэр суманд 3,2 км автозам барих ажлыг Авто зам, замын байгууламжийн барилгын ажилтай холбоотойгоор түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, авто зам, үргэлжлүүлэх зэрэг асуудлыг хугацаанд нь хууль, тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэн ажилласан.

Сүмбэр сум шинээр авто замын ажил гүйцэтгэсэн “Алтай Рөүд” ХХК-д 108 м3 хайрга 810,000 төгрөг, 3327 м3 шар шороо 1,996,200 төгрөг нийт 20,772,000 төгрөгөөр олгосон байна. Шивээговь сум 1900м3 шар шороо, 3558м3 хайргыг 13 ААН-д 24,237,500 сая төгрөгөөр олгосон.

Шивээговь сумын 6.9 км авто замын ажил 17 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол Сүмбэр сумын 3.2 км авто замын 100 хувьтай хийгдэж ашиглалтад хүлээн авсан.

Соёлын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд ууланд “Монгол сакура-Буйлс цэцэглэх хавар” болон “Боржигин өв соёл” эвент арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Үүнд: Монгол сакура-буйлс цэцэглэх үзэгдлийг ажиглах, морь унуулах, байгалийн дурсгалт газрыг танилцуулах зэрэг үйлчилгээ үзүүлж, 77 дотоодын аялагч, 39 гадаадын жуулчин хүлээн авсан.

Чойрын богд ууланд Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошууны хилийн дээсийг эргэж, “Янжив эргэх” уламжлалыг сэргээн, Боржигин шагайн тойром, боржигин өв соёлыг таниулах арга хэмжээг зохион байгуулсан. Жанжин Чойрын ганжуур эргэх ёслолд 1720, МУ-ын гавьяат жүжигчин, морин хуурч И.Цогбадрахыг алдаршуулах Боржигин морин хуурь, уртын



дууны уралдааныг үзэж, сонирхох, оролцохоор 146, Боржигин тойром шагайн харваанд 400 хүн тус тус оролцсон.

Сангийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

Улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөө 1768.3 сая.төгрөг, гүйцэтгэл 2 309.8 буюу 130.6 хувийн, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 10 243.9 сая.төгрөг, гүйцэтгэл 12 192.8 буюу 119.0 хувиар тус тус биелүүлэн ажилласан. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө 2023 онд 499.9 сая.төгрөг, гүйцэтгэл 317.2 сая.төгрөг буюу 63 хувийн биелэлттэй байна. Татвар төлөгчдөд мэдэгдэх хуудас хүргүүлэн ажилласан байна. Үүний үр дүнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем (publicinvestment.gov.mn) ашиглан нийт 4 ажлын санхүүжилтийн гүйцэтгэлийг баталгаажуулан хүргүүлсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

2023 онд Аймгийн хэмжээнд нийт ашигт малтмалын ашиглалтын 13, хайгуулын 3 талбайтай 6 аж ахуйн нэгж байгаагаас одоогоор үйл ажиллагаа явуулж буй Шивээ Овоо ХК байна.

Шивээ-Овоо ХК-ийг хууль журмын хүрээнд дэмжин, хамтран ажиллаж байна.

Шивээ-Овоо ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Шивээговь сумын Засаг даргатай санамж бичиг байгуулж, Чойрын богд уулын аргаль хонины идэш тэжээлд зориулж био техникийн арга хэмжээг зохион байгуулан 2.7 тн хужир тавьж, “Хаялга” нуурын орчмын 50 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Мөн Шивээ-Овоогийн уурхайн 3 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 5000 ширхэг модыг тарьж 19 сая.төг зарцуулсан.

Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын 2, хайгуулын 4 тусгай зөвшөөрөл байна. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох гэрээг 19 иргэн, 18 ААНБ-тэй хийж, орон нутгийн төсөвт 22.5 төгрөг төвлөрүүлж 2.1 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.

Боловсролын шинжлэх ухааны сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд:

Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 640 хүүхдийн барилга ашиглалтанд орсон, 317.0 сая төгрөг төсөвлөсөн ажил хийгдсэн. Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн барилгын ажилд 833.0 төгрөг төсөвлөгдөж 2023 оны гүйцэтгэл 100 хувь бол барилгын ажлын гүйцэтгэлийн хувь 60 хувьтай байна. Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөл 79.0 сая төгрөг батлагдаж, 75 хувьтай байна. Төсөв хүрэхгүй шалтгаанаар “Түмэн алт ХХК”-ийн ажил эхлээгүй байна. Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилга 833.0 сая төгрөг батлагдсан ч 2023 оны 09 сарын 20-иос “Говийн өгөөж” ХХК нэг давхарын цутгалын ажил хийгдсэн. 2 давхарын арматурыг хагас босгосон байна. Барилгын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

Боловсролын салбарын үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлыг 2023 оны 3 дугаар сарын 15, 10 дугаар сарын 8-13 -ны өдрүүдэд Аймгийн Иргэдийн төлөөлчдийн хурлаар танилцуулан шийдвэрлүүлсэн. Үүнд:

Шинээр баригдаж буй сургууль, цэцэрлэгийн барилгыг цаг алдалгүй ашиглалтанд оруулах, “Боловсролыг дэмжих арга хэмжээ” –нд 35.0 сая, “Чадварлаг багш” хөтөлбөр”-т 20.0 сая төгрөг, “Оюутны тэтгэлэг -40.0 сая төгрөг санхүүжүүлэх, Хүүхдийг гэмт хэргээс сэргийлэх цэцэрлэг, сургуулийн бүрэн камержуулахад 168 камерь 78.0 сая төгрөг, 4 сургууль, 5



цэцэрлэгийн ундны усны эх үүсвэрт шүүлтүүр байрлуулах, 23 ус цэвэршүүлэгч шинээр байрлуулахад 27.7 сая төгрөг, Үдийн хоол, хүүхдийн хоолны тоног төхөөрөмж сайжруулахад 3 сургууль 1 цэцэрлэгт аймаг, сумын ОНХС -ын төсвөөр 84.0 сая төгрөг, 2 сургуулийн биеийн тамирын тоног төхөөрөмжийг сайжруулахад 41.0 сая төгрөг, 3 сургууль, 2 цэцэрлэгийн байр, урлаг заалны их засварт 250.0 сая төгрөг, 4 сургуулийн дунд ангийн болон компьютерийн ширээ сандлыг 54.0 сая төгрөг, 2 сургууль, 3 цэцэрлэгийн их засварын зураг төсөв хийхэд 54.0 сая төгрөг, багш нарт орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 14 багшид 18.5 сая төгрөг, 11 компьютер тоног төхөөрөмж 33.0 сая төгрөг дэмжлэг үзүүлэх, сургууль, цэцэрлэгүүдэд тулгамдаж буй урсгал засварын 66.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.

2024 оны төсөвт “Боловсролыг дэмжих арга хэмжээ” 85 сая төгрөг, мөн сургуулийн ариун цэврийн байгууламжийн орчинг сайжруулах, “Шүд угаах хэсэг” байгуулах, ХБХ-ийн сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдүүлэх, ус цэвэршүүлэгчийн тоог нэмэх, Eduten, Pearson хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж 200 таблет, 2 дугаар сургуулийн Дотуур байрны их засвар зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр дэмжиж, сум, аймгийн төсөвт оруулж байна.

Хууль зүйн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

2023 онд 24250 зөрчил, 133 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил 15 хувиар өссөн, гэмт хэрэг 5,0 хувиар буурсан бөгөөд гэмт хэрэг, зөрлийн илрүүлэлт 67,3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4,9 хувиар өссөн байна. Цагдаагийн хэлтэст хурд хэмжигч 2 ширхэг буюу 45,0 сая, камерын иж бүрэн хяналтын дэлгэц 1 ширхэг буюу 19,5 сая, иж бүрэн камерын санах ой төхөөрөмж 1 ширхэг буюу 19,4 сая, 9,0 сая, энгэрийн камер 12 ширхэг буюу 6,2 сая, нийт 90,2 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээний гэмт хэрэг, зөрчлийн криминологи судалгааг IRIM судалгааны байгууллагаар хийлгэж байна. Аймгийн Цагдаагийн хэлтсээс гэмт хэрэг, зөрчлийн гаралтад сар бүр дүн шинжилгээ хийн ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, арга хэмжээ, Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлж, Улсын төсвөөс 594917.0 мян.төг батлагдаж, 1292 хүн хамруулж, төсвийн 445387,1 мян.төг буюу 75 хувийг зарцуулсан байна. Бий болсон байнгын ажлын байрны тоо 60, бий болсон түр ажлын байрны тоо 229, ажилд зуучлагдсан хүн тоо 240, хөдөлмөрт бэлтгэгдсэн хүн тоо 759, ажлын байр хадгалсан 4 иргэн байна.

Ажил олгогчоос гадаад улсаас ажилтан авч ажиллуулах хүсэлтийг хүлээн авч, EJOB мэдээллийн санд байршуулж, 14 хоногийн дотор дотоодоос ажилтан бүртгүүлээгүй тохиолдолд ажил олгогчид холбогдох бичиг баримтыг гаргаж өгч ажиллаж байна. Одоогоор И-жоб платформд ажил хайгчаар бүртгүүлсэн 488 иргэнээс 240 хүнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

2023 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас Говьсүмбэр аймгийн 3 аж ахуйн нэгжийн 3 төсөлд 398 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд өмнөх оноос олгосон зээлийн хэмжээ 32.6 хувиар өссөн байна.

11,290.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 84 төсөл арга хэмжээний тендер зарласан ба тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгох нөхцөлийг 100% тусгасан. 4 компани 162.6 сая төгрөгийн ажиллах хүч, бараа материалын дотоодын давуу эрх тооцуулж тендерт



шалгарсан нь өмнөх оноос 50 хувиар өссөн байна. Монголын арьс ширний нэгдсэн холбоо, ХАА-н биржтэй хамтран цахим сургалтыг 1, танхимын сургалтыг 2 удаа, Сүхбаатар болон Өвөрхангай аймагт үзүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, 57 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулав.

“Арьс, шир, ноос ноолуур бэлтгэн нийлүүлэгчдийн агуулах, түр хадгалах цэгийг стандартын шаардлага хангуулах, тээвэрлэлтийн горим, түүхий эдийн чанарыг хамгаалах” биржийн үйл ажиллагаанд оролцох чиглэлээр бэлтгэн нийлүүлэгчдийг мэдээллээр ханган, 346 тн-ын багтаамж бүхий 7 ш агуулахтай 5 аж ахуйн нэгжийг биржийн байнгын бус гишүүнээр бүртгүүлэн, гэрээ байгуулсан.

Цахим хөгжлийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

Орон нутгийн иргэд, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүсэлт гаргаж 30.0 сая төгрөгийн үнэ бүхий киоск машиныг хүлээн авч иргэдэд тоон гарын үсгийг киоск машинаар олгох боломжтой болсон.

Орон нутгийн зүгээс тоон гарын үсэг олгож буй Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 3.5 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн компьютерээр хангасан.

Мөн аймагт Цахим хөгжлийн хэлтэс байгуулан, аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдэд үйлчлэх төвийг өргөтгөн цахим үйлчилгээний “ХУРДАН” төв байгуулж, 6 цэгт и-монголиа системийн операторыг ажиллуулан иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг тус оператораар дамжуулан олгох үйл ажиллагааг эхлүүлсэн.

Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 16-аас дээш насны 11562 иргэнд иргэнд тоон гарын үсэг олгохоос 2023 онд 5728 иргэн буюу 49.6 хувьд тоон гарын үсгийг олгоод байна. Мөн төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 39 байгууллагын 100 албан хаагч албаны тоон гарын үсэг эзэмшиж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

E-mongolia цахим үйлчилгээнд улсын бүртгэлийн 22 төрлийн лавлагаа, 50 төрлийн үйлчилгээ нэвтрээд байна. Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл цахимжиж цаасан болон цахим архив өдөр тутам үүсгэж, төрийн үйлчилгээнд киоск машины үйлчилгээг нэвтрүүлсэнээр 12 төрлийн лавлагааг үнэ төлбөргүй, тоон гарын үсгийг киоск машинаас авах боломж бүрдэж улсын бүртгэгчээс үйлчилгээ авахаар оочир дугаар үүсгэн 10-15 минутын хугацаа зарцуулдаг байсан бол цахимаар болон киоск машинаар 2-3 минутанд төрийн үйлчилгээ авах нөхцөл бүрдэн төрийн үйлчилгээ түргэн шуурхай чирэгдэлгүй хүрэх боломжтой болсон.

Эдийн засаг, хөгжлийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

Орон нутагтаа нийт 3 төсөл, арга хэмжээний 53.4 тэрбум төгрөгийг гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлсэн байна. Дээрх 3 төсөл, арга хэмжээний хувьд Дулааны станц” байгуулах ажлын гүйцэтгэл 27 хувьтай, Цэвэрлэх байгууламжийн барилга 54 хувьтай, Мандалговь-Чойр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн 540 км автозамын ажил нь 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжинэ.

“Хөдөөгийн сэргэлт” форумд оролцсон талаар “Нээлттэй Говьсүмбэр” зөвлөгөөн орон нутагт зохион байгуулсан талаар www.huduu.mn , www.govisumber.gov.mn 9 цэсэнд Говьсүмбэр аймгийн танилцуулга, хөдөөгийн сэргэлт, ажлын байр, мэдээ, арга хэмжээ, төрийн үйлчлэгээний байгууллагын холбоо барих мэдээлэл зэрэг нийт 383 төрлийн мэдээллийг байршуулж иргэдэд хүргэсэнээр 1143 иргэн хандсан байна.



Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд:

2023 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвөөр лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн амбулаторийн хэсэгт 68.0 сая төгрөг, мооргийн хэсэгт 12.0 сая төгрөг, эргэлтийн хаалганы вакуум хаалт 8 ширхэгийг 13.0 сая төгрөг, нийт 93.0 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж, Гемодиализ, уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээг эхлүүлэн жилийн эцсийн байдлаар гемодиализ эмчилгээг 5 хүнд давхардсан тоогоор 254 удаа, уламжлалтын тасгаар 1580 хүнд тусламж үйлчилгээ үзүүлээд байна.

Хавдрын эрт илрүүлэг үзлэгт нийт 9148 хүнийг хамруулахаас 7155 хүнийг хамруулж, хамрагдалт 78.2 хувьтай байна. Үүнд:

Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 30-60 насны 3467 эмэгтэйчүүд хамрагдахаас 3467 хамрагдаж 100.0 хувьтай, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1186 эмэгтэй хамрагдахаас 436 хамрагдаж 36.8 хувьтай байна. Элэгний хавдарын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 4495 хүн хамрагдахаас 3252 хүн хамрагдаж 72.3 хувьтай байна. Халдварт өвчний 293 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчин 10000 хүн амд 162.7 буюу аймаг /113.4/, улс /118.7/ -ын дундажаас өндөр байна. Халдварт өвчнөөр өвчилсөн 293 хүнийг 100 хувь эмчилгээнд хамруулсан.

Сүрьеэ өвчний 23 шинэ тохиолдол бүртгэгдэн 10 000 хүн амд 12.8 буюу аймаг /6.8/, улс /5.4/ дундажаас өндөр үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 тохиолдлоор өссөн байна. Сүрьеэ өвчнөөр шинээр батлагдсан 23 хүнийг эмчилгээнд хамруулсан.

Тэмбүү өвчний 34 шинэ тохиолдол бүртгэгдэн 10000 хүн амд 18.7 буюу аймаг /8.8/, улс /12.2/ дундажаас өндөр үзүүлэлттэй байна. Тэмбүү өвчнөөр шинээр батлагдсан 34 тохиолдлыг эмчилгээнд хамруулж, эмчилгээний үр дүн 100 хувьтай.

Эрчим хүчний сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд:

“Осо констракшн” ХХК, “Содон Эрчис” ХХК нь 6кВ-ын ЦДАШ болон 1х630 кВА чадалтай хаалттай дэд өртөөний барилга угсралтын ажил дуусч, тоноглох суурилуулах ажил 90 хувьтай явагдаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д аймгийн 470 нэгж талбарын хамгаалалтын бүс, зурвас газруудыг оруулсан.

Сүмбэр сумын Найрамдал хотхонд 36 айлын орон сууцны барилгын ажлын газрын асуудлыг орон нутгаас шийдвэрлэж, төсл сонгон шалгаруулалтыг явуулж, барилгын ажилд “Осо констаркшн” ХХК шалгарч, жилийн эцсийн байдлаар 1-4 дүгээр давхрын цутгамал төмөр бетон каркасын ажлыг гүйцэтгэж байна. Мөн орон сууцны гадна цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд “Шинээр баригдах хотхоны гадна цахилгаан хангамж 6кв ЦДАШ, 2Х630 кВа хаалттай дэд өртөө”-ний ажлыг орон нутгийн төсвийн 240,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Осо-констракшн”ХХК гүйцэтгэж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар дэд өртөөний засал, тоноглолын ажлыг хийх материал татан авалтын ажил хийгдэж байна. Ажил 90% хийгдсэн байна.

Тагт, Гашууны эгнээнд цахилгаан эрчим хүч тасалдах асуудлыг шийдвэрлэхийн тулд 0,45 км 6 кВа-ын агаарын шугам, 4,5 км 0,4кВ агаарын шугамуудыг солих шинэчлэх, 250 кВа дэд өртөө барих зэрэг ажлуудыг 2024 оны хийхээр төлөвлөж байна.



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд:

7 га талбайд ойн зурвас шинээр байгуулан, ойн зурвас газрын хэмжээ 54 гад хүрч, аймгийн мод үржүүлгийн газрыг өргөтгөж, 52474 тарьц, суулгац шинээр тариалж, мод, бутны амьдралд ургалт 80 хувьд хүрсэн.

ХХААХҮЯ-ны дэмжлэгтэйгээр 2022 онд байгуулагдсан 3 га “Жимсний мод үржүүлгийн төв”-ийн газарт 816 ш хайлаас, улиасны хамгаалалтын зурвас, чацарганын 3 сорт (Чуйская, Элизабет, Солнечная) үхрийн нүдний (Элбэг, Приморский чемпион, хөх далан хальсийн 2 сорт (Blue berry, cinderella), Бэсрэг алим, интоор, лийрийн нийт 1380 ш жимсний модыг тариалж, ургалт 74 хувьтай байна.

Шадар сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгөөр эргүүл хийх зориулалттай “YULE” маркийн 18 морины хүчин чадалтай 5 хүний багтаамжтай моторт завийг худалдан авах Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрээр 20 км-ын урсацтай “Хэрлэн гол”, Шивээговь сумын 2 дугаар багт байрлах “Хаялага нуур”-ын эрэг дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд 30 сая төгрөг, Газар хөдлөлтийн хурдатгал хэмжих төхөөрөмж болон моторт завь худалдан авах 30 сая, иргэдийн сургалт арга зүйн төв байгуулах зураг төсөл хийлгэх 20 сая нийт 80 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Дүгнэлт: 2023 онд Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн байна. Гэвч хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, үр дүнг сайжруулах зорилгоор цаашид дараах зүйлд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Гэрээнд тусгагдсан арга хэмжээний төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах, арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгжих боломжтой, төсөв хөрөнгө, зохион байгуулалтын хувьд шийдвэрлэх боломжтой байхад анхаарч, суурь болон зорилтот түвшин тодорхой, үнэлэх боломжтой байхад анхаарах.

- Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 тал бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, үр дүнтэй хамтран ажиллаж, үр нөлөөг дээшлүүлэх.

4.2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Говьсүмбэр аймгийн стратеги төлөвлөгөө, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон бодлогын баримт бичигтэй уялдуулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу зорилт, арга хэмжээний уялдааг хангаж, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг уялдуулан Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд 18 зорилт, 138 арга хэмжээ, Хуулиар тусгайлан олгосон буюу нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 1 зорилт, 9 арга хэмжээ, Төрийн үйлчилгээний



чанар, хүртээмжийг сайжруулах 3 зорилт, 28 арга хэмжээ, нийт 22 зорилт, 175 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, зааварт тавигдах шаардлагыг хангуулан, зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, хүрсэн түвшинг хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнасан байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах зорилгоор байгууллагын зохион байгуулалтын нэгж, хэлтэс, алба, цаашлаад төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, нэгжийн болон албан хаагчийн ажлыг сараар төлөвлүүлэн, хэрэгжилтийг тооцож, 1 болон 3 дугаар улиралд ярилцлага хийн, гүйцэтгэлийг сайжруулах, хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөмж өгч, хагас, бүтэн жилээр гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, дүгнэн ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзвэл Бодлогын баримт бичигт тусгагдсан 18 зорилтын 138 арга хэмжээг дунджаар 87.6 хувьтай, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 1 зорилт, 9 арга хэмжээг дунджаар 93.3 хувьтай, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 зорилтын 28 арга хэмжээг 92.4 хувьтай, дунджаар 22 зорилтын 175 арга хэмжээг **90.5 хувьтай** хэрэгжүүлэн ажилласан байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 12. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Чиг үүрэг, зорилт	Төлөвлөсөн		Тайлагнасан		Хэрэгжилтийн хувь
		Зорилт	Арга хэмжээ	Зорилт	Арга хэмжээ	
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан чиг үүрэг	18	138	18	138	87.6
2	Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг	1	9	1	9	93.3
3	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	3	28	3	28	92.4
Нийт		22	175	22	175	90.5

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд 117 арга хэмжээг 100 хувь, 53 арга хэмжээг 90 хувь, 16 арга хэмжээг 70 хувь, 8 арга хэмжээг 50 хувь, 3 арга хэмжээг 30 хувийн гүйцэтгэлтэй, дунджаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг 90.5 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна. Үнэлгээг дараах хүснэгт болон графикаар харуулав.



Хүснэгт.13.Гүйцэтгэлийн үнэлгээ

Үнэлгээ	Арга хэмжээний тоо	
	2022 он	2023 он
100%	123	117
90%	27	53
70%	39	16
50%	5	8
30%	4	3
0%	-	-
Дундаж хэрэгжилтийн хувь	90.93	90.5




График. Гүйцэтгэлийн үнэлгээний харьцуулалт

Холбогдох журам, аргачлалын дагуу байгууллагын 2023 оны төлөвлөгөөнд 2022 онд төлөвлөсөн боловч хүрэх түвшиндээ хүрээгүй, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээг тусган төлөвлөж, хэрэгжилтийг хангуулсан. Үүнд:

1. Мал аж ахуйн гаралтай экспортод чиглэсэн бүтээгдэхүүн, түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. 2022 онд –40, 2023 онд-85
2. Сүмбэр хонины тоо толгойг өсгөх, удмын санг хамгаалах, генетик нөөцийг зохистой ашиглах, бүртгэнэ. 2022 онд –66.6, 2023 онд - 70
3. Хөнгөн, бичил, жижиг дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл болон тоног төхөөрөмжийн дэмжлэгт хамруулна. 2022 онд –40 2023 онд -100
4. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулан, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. 2022 онд –67.5, 2023 онд -100
5. 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. 2022 онд –40, 2023 онд -40
6. Орон сууц, хаус хороолол барих санал санаачилгыг дэд бүтэц болон газрын бодлогоор дэмжинэ. 2022 онд – 40, 2023 онд -100
7. Аймгийн төвийн айл өрхүүдийг ухаалаг тоолуур, гэр хорооллын айл өрхүүдэд утаагүй түлшний хэрэглээг нэвтрүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна. 2022 онд –62.5, 2023 онд -90
8. Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулна. 2022 онд –66.6, 2023 онд -100

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хүрээнд 2023 онд тусгагдсан боловч хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх, үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай дараах арга хэмжээг 2024 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай. Үүнд:

1. Аймаг, сумдын төвд явган замын сүлжээг нэмэгдүүлнэ.
2. 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.



3. Шинээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бүрэн тусгаж, аж ахуйн нэгж, албан байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлнэ.
4. Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.
5. Сүмбэр суманд автозамын зураг төсөв боловсруулах ажил
6. Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй болон төгсөөд орон нутагтаа ажиллах оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.
7. Дэд бүтцэд тулгуурлан тээвэр, логистикийн төв байгуулна.
8. Аймаг, сумдын төвд шинээр авто зам барьж, улсын чанартай авто замтай холбоно.
9. Сүмбэр сумын 1-р баг Тээвэрчдийн өргөн чөлөөнөөс 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил
10. Орон нутгийн аюулгүй байдлыг хангах үүднээс бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий хүнсний агуулах барихыг дэмжинэ.
11. Хөдөө аж ахуйн газрын хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх
12. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус болон халдварт өвчний урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг шинжилгээг зохион байгуулах.

4.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд авч хэрэгжүүлсэн хүний нөөцийг хөгжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2 зорилтын, 7 үйл ажиллагааны 14 шалгуур үзүүлэлтийг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн 2023 оны жилийн эцсийн тайлан, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн, бодит нөхцөл байдлыг тодруулах зэргийг харгалзан үзлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 2023 оны гүйцэтгэлийг **98.6 хувиар** үнэлж, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 14. “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
1	2	3	4	5	6	7
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	20	60	Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн 26 удаагийн цахим сургалтад 185, Алсын хараа 2050 “Шинэ Сэргэлтийн Бодлого”-ын цахим, танхимын хосолсон сургалтад 42, ERP системийн сургалтад 10, Төрийн байгууллагын нягтлан бодогч, нярвыг



хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнэ эс	Ажлын байран дахь сургалт	15	21	<p>чадавхжуулах сургалтад 4, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад 15, Удирдлагын академийн “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сургалтад 1, “Бодлогын баримт бичгийн төлөвлөлт” сургалтад 8, “Цахим аймаг” цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад 7, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулга, хэлэлцүүлэгт 22, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран “Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-д 39, төрийн албан хаагчийн нэгдсэн сургалтад 35 нийт давхардсан тоогоор 368 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Ажлын байран дахь сургалт: Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна. 2023 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 21 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 651 албан хаагчийг хамруулсан. Мөн Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтад 6 албан хаагч хамрагдаж сертификат авсан.</p> <p>Мэргэшүүлэх сургалт: Төрийн албаны тухай хуулийн дагуу мэргэшүүлэх сургалтуудад нийт 16 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Үүнд: Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад – 3, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад – 2, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад – 1, Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад-1, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 9</p> <p>Туршлага судлах арга хэмжээ: Зүүн аймгуудын Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан туршлага судлах үйл ажиллагаанд 16 албан хаагчийг хамруулсан. Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ухай хот дахь “Соу лон га” Эрчим хүч Технологийн ХХК-тай “Хөдөө орон нутаг, бэлчээрийн мал аж ахуйн хог хаягдлыг хурдан пиролиз хийх, хор хөнөөлгүй цэвэрлэх төхөөрөмжийн үйл ажиллагааг танилцуулах, туршлага судлуулах арга хэмжээнд 4 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Хүрсэн түвшин: Нийт 60 удаагийн сургалт, 2 удаагийн туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 1061 албан хаагч буюу 51 төрийн албан хаагчийг хамруулсан нь нийт албан хаагчийн 100 хувийг сургаж, чадавхжуулсан байна.</p>		
		Мэргэшүүлэх сургалт	5	34			
		Туршлага солилцох арга хэмжээ	-	2			
		Бусад	-	3			
	1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	51	51			
	Үүнэ эс	Эмэгтэй албан хаагч	30	33			
		Эрэгтэй албан хаагч	16	18			
		Удирдах албан тушаалтан	9	9			
		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	35	42			
	1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100%			
	Хэрэгжилтийн хувь					100 хувь	
	2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо		1	7
			2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:		2-оос дээш	9
Үүнэ эс			Эмэгтэй албан хаагч	1	3		
			Эрэгтэй албан хаагч	1	6		
			Удирдах албан тушаалтан	1	9		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	1	0		
2.3.			Гадаад сургалтад хамруулсан байдал:	20-оос дээш	56.6 хувь		
3 удаагийн сургалт, арга хэмжээнд нийт 6 албан хаагчийг хамруулсан бөгөөд цахимаар 6, танхимаар 1 албан хаагч тус тус хамрагдсан байна.							



		Нийт албан хаагчдад эзлэх хувь					
Хэрэгжилт, хувь						96.35 хувь	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	66,180,000 төгрөг	Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтанд 6 албан хаагчийг хамруулж, 480,000 төг зарцуулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар "Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө"-г шинэчлэн 68.0 сая төгрөгөөр 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан. Энэхүү арга хэмжээний зардлаас албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд 32.7 сая төгрөг, Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээний зардлаар 30 албан хаагчийг гадаад сургалт, семинар, арга хэмжээнд хамруулж, 33.0 сая төгрөгийг зарцуулсан. Хүрсэн түвшин: Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ 66,180,000 төгрөг	
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	11.6 хувь	Аймгийн ЗДТГазарт 2023 онд 61 орон тоо батлагдсанаас 6 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, хугацааны эхэнд 50 албан хаагч, хугацааны төгсгөлд 53 албан хаагч ажилласан байна. Шилжилт хөдөлгөөнийг дараах томъёогоор тооцов. $\frac{\text{Чөлөөлөгдсөн албан Шилжилт хөдөлгөөн}}{\text{Албан хаагчдын дундаж тоо}} = \frac{\text{Хаагчдын тоо} * 100}{\text{Албан хаагчдын дундаж тоо}}$ Хүрсэн түвшин: Чөлөөлөгдсөн албан хаагчийн тоо-6 Тайлант оны эхэнд ажиллаж байсан албан хаагчийн тоо-50 Тайлант оны төгсгөлд ажиллаж байсан албан хаагчийн тоо-53 Шилжилт, хөдөлгөөний хувь – 11.6 хувь	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						100 хувь	
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	Батлагдсан төсвийн дагуу	Байгууллагын нийт төсөв 3,064,853,200	2023 онд нийт 61 орон тоо батлагдсанаас 53 албан хаагчийн цалин хөлсөнд 1,305,964,662 төгрөг, 13 албан хаагчид 12,900,000 төгрөгийн шагнал, 51 албан хаагчид 76,725,885 төгрөгийн урамшуулал, нийт 1,395,590,547 төгрөгийн цалин хөлс, шагнал, урамшуулал олгосон нь байгууллагын нийт төсвийн 45,5 хувийг цалин хөлс, шагнал, урамшуулалд зарцуулсан байна. Хүрсэн түвшин: Нийт батлагдсан төсөв: 3,064,853,200 төгрөг Зарцуулсан төсөв: 1,395,590,547 Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь-45.5 хувь	
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	3.0	5.0	2023 онд байгууллагын дотоод журмын дагуу өдрийн хоол, унааны зардлыг 5000 төгрөгөөр тооцон 1-12 сарын хоол унааны зардалд 55,664,000 төгрөгийг 53 албан хаагчдад олгосон.	
Хэрэгжилтийн хувь						100 хувь	
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	90.0	2023 онд байгууллагын уур амьсгал, таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг нийт 53 албан хаагчаас авахаас 41 албан хаагч буюу 77 хувийг хамруулсан байна. Судалгааны дүнгээс харахад 90.0 хувь сайн гэж үнэлсэн нь өмнөх оноос 5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Албан хаагчдын ажлын байрны орчин нөхцлийг сайжруулахад анхаарч	



						байгууллагын 2, 3 дугаар давхарыг засварласан. 12 албан хаагчийн компьютер, принтерийг шинэчилсэн. Албан хаагчдын гүйцэтгэлийн үр дүнг “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу улирал бүр дүгнэж, хагас, бүтэн жилээр үнэлэн урамшуулал олгосон. Орон нутгийн нэмэгдлийг 1-6 сар хүртэл 100 хувиар, 6-12 сар хүртэл 30 хувиар олгосон бөгөөд нийт давхардсан тоогоор 312 албан хаагчид 240,314,229 төгрөгийн нэмэгдэл олгосон. Хүрсэн түвшин: Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн-90 хувь
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1	Улсын хэмжээнд зохион байгуулагдсан эрт илрүүлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд 51 албан хаагчаас 45 албан хаагчийг хамруулснаар нийт албан хаагчдын 88.2 хувь нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	88.2 хувь	
Хэрэгжилтийн хувь						90 хувь
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Батлагдсан төсвийн дагуу	Батлагдсан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 38 320 600	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчид тэтгэмж олгох, тусламж үзүүлэх, нөхөн төлбөр олгох гэж заасны дагуу нийт 26,800,000 төгрөгийг давхардсан тоогоор 34 албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан. Үүнд: Нэг удаагийн буцалтгүй тусламж 4,500,000 төгрөг (7 албан хаагч) Шагнал 13,000,000 төгрөг (11 албан хаагч) Дэмжлэг 9,300,000 төгрөг (16 албан хаагч) Хүрсэн түвшин: Батлагдсан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал-38 320 600 Зарцуулсан төсөв- 26,800,000
						Хэрэгжилтийн хувь
Дундаж хэрэгжилт						98.95хувь

Аймгийн Засаг даргын захирамжаар “Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний төлөвлөгөө”-г шинэчлэн 68.0 сая төгрөгөөр 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан. Энэхүү арга хэмжээний зардлаас албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд 32,7 сая төгрөг, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээний зардлаар 30 албан хаагчийг гадаад сургалт, семинар, арга хэмжээнд хамруулж, 33 сая төгрөгийг зарцуулсан. Мөн худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтанд 6 албан хаагчийг хамруулж 480.000 төгрөг нийт 66.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд сургалт, хөгжлийн чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Засгийн газар, төрийн байгууллага бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт: Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи болон бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр нийт 60





удаагийн сургалт, 2 удаагийн туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 1061 албан хаагч буюу 51 төрийн албан хаагчийг хамруулсан нь нийт албан хаагчдыг 100 хувь сургаж, чадавхжуулсан.

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн 26 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 185 албан хаагч, “Алсын хараа 2050”, “Шинэ Сэргэлтийн Бодлого”-ын цахим, танхимын хосолсон сургалтанд орон нутгийн 42 албан хаагчийг тус тус хамруулсан.


ERP системийн сургалтад 10 албан хаагч, Төрийн байгууллагын нягтлан бодогч, няравыг чадавхжуулах сургалтад 4 албан хаагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад 15 албан хаагч, Удирдлагын академиас зохион байгуулсан “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сургалтад 1 албан хаагч, “Бодлогын баримт бичгийн төлөвлөлт” сургалтад 8 албан хаагч, “Цахим аймаг” цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад 7 албан хаагч, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулга, хэлэлцүүлэгт 22 албан хаагч, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран “Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-д 39 албан хаагч, төрийн албан хаагчийн нэгдсэн сургалтад 35 албан хаагч нийт давхардсан тоогоор 368 албан хаагчийг бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамруулсан.



2. Туршлага судлах арга хэмжээ: Зүүн аймгуудын Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааг бэхжүүлэн, харилцан туршлага судлах үйл ажиллагаанд 16 албан хаагчийг хамруулсан. Мөн Өвөр Монголын өөртөө засах орны Ухай хот дахь Соу лон га Эрчим хүч Технологийн ХХК-тай “Хөдөө орон нутаг, бэлчээрийн мал аж ахуйн хог хаягдлыг хурдан пиролиз хийх, хор хөнөөлгүй цэвэрлэх төхөөрөмжийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор 4 албан хаагчийг туршлага судлуулсан.



3. Байгууллагын дотоод сургалт: Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг жил бүр төлөвлөн хэрэгжүүлдэг. 2023 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 21 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 651 албан хаагчийг хамруулсан.



4. Мэргэшүүлэх сургалт: Төрийн албаны тухай хуулийн дагуу мэргэшүүлэх багц сургалтуудад нийт 16 албан хаагчийг хамруулсан. Үүнд:

- Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3
- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2
- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1
- Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад-1
- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 9 албан хаагч тус тус хамрагдсан байна.



Мөн Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сертификатын сургалтад 6 албан хаагчийг хамруулсан.

5. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт: Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах уралдаан, тэмцээн, бусад арга хэмжээнд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийг оролцоход дэмжлэг үзүүлэхээр 55.0 сая төгрөгийг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан. Тайлант хугацаанд Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнжу мужад 2023 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан “NEAR”-2023 гадаад харилцааны мэргэжилтнүүдийн уулзалтад 2 албан хаагч, Бүгд Найрамдах Солонгос улсад 2023 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан “NEAR”-14 дүгээр бүгд хуралд 2 албан хаагч, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнжу мужад 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан “NEAR-2023” Олон улсын форум уулзалтад 2 албан хаагч, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Жиангсу мужийн Үши хоттой 2022 онд байгуулсан найрсаг харилцаа, хамтын ажиллагаа тогтоох санамж бичгийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 17–22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Интоорын мод цэцэглэх олон улсын фестиваль”-д 2 албан хаагч, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шэньси хотод 2023 оны 11 дүгээр сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол улс, Хятад улсын хамтарсан “Торгоны зам”-ын 7 дахь удаагийн олон улсын экспод 1 албан хаагч, Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотод зохион байгуулагдсан “Монгол Улсын төрийн албан хаагчдад зориулсан төрийн албаны манлайлал сургалт”-д 2 албан хаагч, Өвөр Монголын өөртөө засах орны Ухай хот дахь Соу лон га Эрчим хүч Технологийн ХХК-тай хөдөө орон нутаг, бэлчээрийн мал аж ахуйн хог хаягдлыг хурдан пиролиз хийх, хор хөнөөлгүй цэвэрлэх төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлуулахаар 4 албан хаагч, Бүгд Найрамдах Солонгос улсын Намьянжу хотын Эль болон Чамчуван эмнэлэгтэй байгуулсан гэрээний хүрээнд туршлага судлахаар аймгийн нэгдсэн




эмнэлгийн 4 эмч, Бүгд Найрамдах Солонгос улсын урлагийн Евон их сургуультай байгуулсан гэрээний хүрээнд 6 албан хаагчийг туршлага судлуулсан.



6. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх: 2023 онд нийт 61 орон тоо батлагдсанаас 53 албан хаагчийн цалин хөлсөнд 1,305,964,662 төгрөг, 13 албан хаагчид 12,900,000 төгрөгийн шагнал, 51 албан хаагчид 76,725,885 төгрөгийн урамшуулал, нийт 1,395,590,547 төгрөгийн цалин хөлс, шагнал, урамшуулал олгосон нь байгууллагын нийт төсвийн 45.5 хувийг цалин хөлс, шагнал, урамшуулалд зарцуулсан нь өмнөх оноос 609.7 сая төгрөг буюу 43.7 хувиар өссөн байна. Мөн нэг удаагийн буцалтгүй тусламжийг 7 албан хаагчдад 4,500,000 төгрөг, 11 албан хаагчдын шагналд 13,000,000 төгрөг, 16 албан хаагчдад 9,300,000 төгрөгийн дэмжлэг нийт давхардсан тоогоор 34 албан хаагчдад 26,800,000 төгрөгийн тэтгэмж, тусламж олгож нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлсэн.



Орон нутгийн нэмэгдлийг 1-6 сар хүртэл 100 хувиар, 6-12 сар хүртэл 30 хувиар олгосон бөгөөд нийт давхардсан тоогоор 312 албан хаагчид 240,314,229 төгрөгийн нэмэгдэл, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу өдрийн хоол, унааны зардлыг 5000 төгрөгөөр тооцон 1-12 сарын хоол унааны зардалд 55,664,000 төгрөгийг 53 албан хаагчдад тус тус олгосон байна.



7. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх: Албан хаагчдын ажлын байрны орчин нөхцлийг сайжруулахад анхаарч байгууллагын 2, 3 дугаар давхарыг бүрэн засварлаж 12 өрөөний хаалгыг шинэчилж, хурлын заалыг өргөтгөн ОНХС-ийн 330 сая төгрөгийн хөрөнгөөр засварлаж тохижуулсан. Мөн 12 албан хаагчийн компьютер, принтерийг шинэчилсэн.



8. Эрүүл мэндийн эрт илрүүлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд 51 албан хаагчаас 45 албан хаагчийг хамруулснаар нийт албан хаагчдын 88.2 хувь нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.



9. Албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг 2023 оны 02 дугаар сар, 2023 оны 10 дугаар сард тус тус авахад дундаж сэтгэл ханамжийн түвшин 81.9 хувьтай байсан бол 90.0 хувь болж 8.1 хувиар өссөн байна. Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн байгууллагын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, цалин хөлс, дэмжлэг тусламж, тэтгэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд цаашид албан хаагчдын хамтын ажиллагааг дэмжих, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн нь эерэг үр нөлөөтэй байна. (Сэтгэл ханамжийн судалгааны дүнг хэрэглэгчийн үнэлгээ хэсэгт оруулав)

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

5.1. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт

Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт-ийг “Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал” бүлгийн 10 шалгуур үзүүлэлт, “Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал” бүлгийн 6 шалгуур үзүүлэлт, “Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал” бүлгийн 15 шалгуур үзүүлэлт, “Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал” бүлгийн 2 шалгуур үзүүлэлт, “Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал” бүлгийн 13 шалгуур үзүүлэлт нийт 5 бүлгийн 46 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ **98.67 хувиар** үнэлэгдсэн.

Ил тод байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах, мэдээ, мэдээллийн чанар хүртээмжийг чанаржуулах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд гарсан өөрчлөлтийг хэмжих үүднээс шалгуур үзүүлэлтийн утга нь суурь түвшин болон өмнөх оноос хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээллийг үндсэн тайланд тусгаж, www.new.unelgee.mn цахим системд нотлох баримт, дэлгэрэнгүй тайлан, бүртгэл судалгааг хавсаргаж тайлагнасан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 15. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

Нийт тайлагнах шалгуур үзүүлэлтийн тоо		46
Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн тоо		10
Бүрэн хэрэгжсэн	100%	10
Хэрэгжих шатанд	70%	-
Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Хэсгийн дундаж хувь		100%
Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн тоо		6
Бүрэн хэрэгжсэн	100%	6
Хэрэгжих шатанд	70%	-



Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Хэсгийн дундаж хувь		100%
Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн тоо		15
Бүрэн хэрэгжсэн	100%	15
Хэрэгжих шатанд	70%	-
Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Хэсгийн дундаж хувь		100%
Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн тоо		2
Бүрэн хэрэгжсэн	100%	2
Хэрэгжих шатанд	70%	-
Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Хэсгийн дундаж хувь		100%
Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн тоо		13
Бүрэн хэрэгжсэн	100%	10
Хэрэгжих шатанд	70%	2
Хэрэгжилт хангалтгүй	30%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	1
Хэсгийн дундаж хувь		95.0
Хэрэгжилтийн дундаж хувь		98.67

Дээрх хүснэгтээс харахад Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг 100 хувь, Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг 100 хувь, Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг 100 хувь, Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг 100 хувь, Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг 95.0 хувь тус тус хангасан байна.



Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 1 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:


- 5.2 Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт: Дээрх 1 шалгуур үзүүлэлтийн хувьд мэдээлэл хариуцагчийн зүгээс хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил болон эзэмшиж байгаа оюуны өмчийн эрх байхгүй байгаагаас “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” гэж үнэллээ.

Ил тод байдлыг хангах чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газраас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн албан ёсны цахим хуудас www.govisumber.gov.mn цахим хуудас, пэйж хуудас, Говьсүмбэр аймаг, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар фэйсбүүк хуудас, олон нийтийн сүлжээ болон мэдээллийн самбар, орон нутгийн Говьсүмбэр телевиз, МҮОНТ, ТВ-9, 25 дугаар суваг телевиз, МҮОНР зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага, хэрэгслээр мэдээллийг хүргэн ажиллаж, цахим хуудсанд 559, олон нийтийн сүлжээгээр 398 мэдээ мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 10917 иргэнд мэдээллийг хүргэсэн. Мөн Орон нутгийн Говьсүмбэр телевизээр 55 мэдээлэл, ТВ-9 телевизээр 3 мэдээлэл, МҮОНТ-ээр 11 удаагийн мэдээллийг бэлтгэн хүргэсэн.




Аймгийн Засаг даргын Тамгын газарт ISO MNS 9001:2016 “Чанарын менежментийн тогтолцоо” нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын брэндбүүкийг бий болгон байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр мэдээллийг иргэдэд ойлгомжтой, шинэлэг байдлаар, цаг тухайд нь хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, байгууллагын угтах хэсэгт мэдээллийн самбаруудыг байршуулан, мэдээллийг шинэчлэн ажилласан. Мөн төрийн албыг чирэгдэлгүй хүргэх үүднээс угтах самбар, өрөөнүүдийн хаягжилт, албан хаагчдын мэдээллийг монгол, англи, уламжлалт монгол бичгээр хослуулан шинэчлэн байршуулсан байна.





“Монголын мэдээ” сонинтой гэрээ байгуулан хамтран ажиллаж сонины захиалгат тусгай дугаарт ил тод байдлыг хангахад чиглэсэн цаг үеийн бүхий л мэдээ, мэдээллүүд нийтлүүлж, 3000 ширхэг сонинг иргэдэд хүргэсэн. Мөн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор “Говьсүмбэр энэ 7 хоногт” тойм мэдээг 12 удаа, 4 богино хэмжээний видео шторкийг бэлтгэн давхардсан тоогоор 10267 иргэнд хүргэсэн байна.





Говьсүмбэр энэ 7 хоногт /2023.11.20-11.26/

“Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд “Нээлттэй Говьсүмбэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэн “Хөдөөгийн сэргэлт” форумаар 342 иргэнд мэдээллийг хүргэсэн бол www.huduu.mn цахим хуудсанд Говьсүмбэр аймгийн танилцуулга, хөдөөгийн сэргэлт, ажлын байр, мэдээ, арга хэмжээ, төрийн үйлчилгээний байгууллагын холбоо барих мэдээлэл зэрэг 28 байгууллагын 643 мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэснээр 1182 иргэний хандалт авч 21 аймгаас нэгдүгээрт бичигдэж байна.

Төрийн цахим үйлчилгээний e-mongolia системд Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 нэр төрлийн үйлчилгээг цахимжуулсан бөгөөд төрийн цахим үйлчилгээний “ХУР-ДАН” төвийг 5 цэгт байгуулан 2023 онд 55 төрлийн төрийн цахим үйлчилгээг 5559 иргэнд оперторийн системээр үзүүлсэн.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг <https://haaa.gs.gov.mn/> цахим хуудаст бүрэн байршуулсан. 2023 онд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 18,018.19 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 61 бараа, ажил, үйлчилгээг хууль, журмын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зохион байгуулсан. Төсвийн ерөнхийлөн захирагч 61 тендер шалгаруулалтын 115 урилгыг цахим хэлбэрээр нийтэлсэн. Үүнээс шалгарсан 42, шалгараагүй 87 тендер оролцогчдод шалгарсан болон шалгараагүй тухай мэдэгдэлийг захиалагч болон тендер оролцогчдод хүргүүлсэн.






5.2. Шилэн дансны хөтлөлт:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа аймгийн төсвийн 31 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 4, сан, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ 8 байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 43 байгууллагын шилэн дансны дундаж хэрэгжилт 96.0 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.4 хувиар өссөн бөгөөд төсвийн шууд захирагч нар нь Шилэн дансны тухай хуулийг “хангалттай сайн” хэрэгжүүлж байна.



2023 оны шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийн давтамж, хугацаандаа оруулсан байдлыг харгалзан үнэлж, үнэлгээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 16. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

№	Байгууллагын нэр	Шилэн дансны үнэлгээ	
		Хагас жил	Жилийн эцэс
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	97.3	98.7
2	Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар	99.0	99.5
3	Баянтал сумын Засаг даргын Тамгын газар	96.4	91.6
4	Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар	99.0	94.6
5	1 дүгээр цэцэрлэг	100	100
6	2 дугаар цэцэрлэг	98.8	99.5
7	3 дугаар цэцэрлэг	90.7	93.6
8	4 дүгээр цэцэрлэг	93.6	94.2
9	5 дугаар цэцэрлэг	100	100
10	6 дугаар цэцэрлэг	91.6	95.8
11	1 дүгээр сургууль	100	99.4
12	2 дугаар сургууль	87.5	93.2
13	3 дугаар сургууль	99.0	96.8
14	4 дүгээр сургууль	90.7	95.4
15	5 дугаар сургууль	100	100
16	Баянтал сумын ЭМТөв	89.8	89.6
17	Шивээговь сумын ЭМТөв	100	99.4
18	Ус-Ду ОНӨААТҮГ	87.6	92.5
19	Илчлэг шивээ ОНӨААТҮГ	91.8	93.9
20	Талын Илч ОНӨААТҮГ	97.9	97.6
21	Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ	97.7	96.9
22	Цөм сүрэг үржлийн төв	80.6	77.6
23	Сум дундын ойн анги	97.9	99.0
24	Авто замын сан	98.7	95.2
25	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	100	100
26	Орон нутгийн өмчийн газар	100	100



27	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	97.4	98.7
28	Ахмадын хороо	100	100
29	Боржигин өв музей	98.9	99.5
30	Шивээговь сумын соёлын төв	97.4	93.8
31	Баянтал сумын соёлын төв	98.7	98.7
32	Нийтийн номын сан	100	100
33	Боржигин чуулга	88.5	93.6
34	Халамжийн сан	95.9	95.4
35	Аймгийн ОНХСан	97.4	98.1
36	Сүмбэр сумын ОНХСан	95.5	97.7
37	Баянтал сумын ОНХСан	86.6	91.3
38	Шивээговь сумын ОНХСан	83.5	91.2
39	Сүмбэр сумын СХСан	100	100
40	Баянтал сумын СХСан	83.3	91.7
41	Шивээговь сумын СХСан	78.3	85.8
42	Политехник коллеж	100	98.8
43	Насан туршийн боловсролын төв	100	98.3

2023 онд Шилэн дансны цахим хуудсанд өөрчлөлт оруулсантай холбоотой байгууллагуудын бүртгэлийг шинэчилж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний 43 сан, ОНӨҮГазар, төсвийн байгууллагуудад хяналт тавьж ажиллаж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр томилогдсон нягтлан бодогчдод Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цахим хуудсанд мэдээлэл хэрхэн оруулах тухай болон санхүүгийн сахилга баттай ажиллах, түгээмэл гардаг санхүүгийн зөрчлүүдийн талаар сургалт, зөвлөмж, зааварчилгааг өгч ажилласан. Мөн 33 байгууллагын баримтыг татан авч нийцлийн аудит хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

Цаашид Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх чиглэлээр төсвийн байгууллагуудын шилэн дансны хөтлөлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, мэдээллийн чанар, хугацаанд нь оруулж байгаа байдалд хяналт шалгалт хийн алдаа, дутагдлыг арилгуулах, төсвийн болон орон нутгийн байгууллагуудын шилэн дансанд мэдээлэл оруулж байгаа албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

5.3. Шударга байдлын түвшин:

Шударга байдлын түвшинг тодорхойлох чиглэлээр “Хууль зүйн сайд, аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ”, аймгийн 2023 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайлан, төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн үнэлэлт, дүгнэлт өглөө.

Авлигын эсрэг үйл ажиллагаа: Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас 2023 онд авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд 5 зорилтын 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 15 арга хэмжээг 100 хувь буюу үр дүнтэй, 1 арга хэмжээг тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувьтай хэрэгжүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг 98.1 хувьтай ханган ажилласан бөгөөд өмнөх оны авлигын эсрэг үйл ажиллагааны гүйцэтгэл 0.3 хувиар өссөн байна. Авлигын эсрэг дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн 14 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж 469 иргэнийг хамруулж, Авлига,



ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 11 төрлийн постерыг аймгийн ЗДТГ www.govisumber.gov.mn цахим хуудас, Хууль, эрх зүйн хэлтсийн олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэж, давхардсан тоогоор 1001182 иргэнд мэдээллийг хүргэсэн.

- Иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газар болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс бэлтгэсэн тв шторк, инфографик, видеог иргэдэд хүргэж, Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын эсрэг нэгдье-2023” аяныг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, малчид, хувиараа бизнес эрхлэгчид, төрийн байгууллагуудын албан хаагчид нийт 1182 хүнийг хамруулсан.



- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал сэдэвт сургалтыг зохион байгуулж, төрийн болон орон нутгийн өмчит 15 байгууллагын 106 албан хаагч, сумдын ЗДТГ-ын 80 албан хаагч, төрийн болон орон нутгийн байгууллагуудын 110 төсөв, санхүүгийн ажилтнуудыг хамруулсан.



- “Хуульчийн про-боно” өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх гарын авлагыг бэлтгэн 150 иргэнд тараасан. “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд “АТГ-ын Олон нийтийн төв”, “Шударга ёс, хөгжил дэвшил-Авлигатай тэмцэх газар” стенийг бэлтгэж сургалт, сурталчилгаанд ашиглаж байна.



- Нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд 2023 онд 97 албан хаагч ХАСХОМ мэдүүлэхээс 97 албан хаагч хугацаандаа мэдүүлсэн.

- Мөн төрийн болон нийтийн албанд томилогдож байгаа 11 албан хаагч ХАСУМ мэдүүлснийг хууль, тогтоомжийн хүрээнд нийтэд ил тод мэдээлж, аймгийн албан ёсны www.govisumber.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

Авлигын эсрэг үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг **90.5 хувьтай** үнэллээ.

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт.17. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

№	Байгууллагын нэр	Хэрэгжилт, хувь
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	98.1
2	Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар	93.5
3	Баянтал сумын Засаг даргын Тамгын газар	81.2
4	Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар	92.6
5	Онцгой байдлын газар	95.6
6	Цагдаагийн хэлтэс	95.6
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 425 дугаар анги	95.0
8	Шүүхийн шинжилгээний алба	95.0
9	Улсын бүртгэлийн хэлтэс	94.1
10	Санхүүгийн хяналт, аудитын алба	94.5
11	Татварын хэлтэс	95.0



12	Статистикийн хэлтэс	97.0
13	Боловсрол, шинжлэх ухааны газар	86.0
14	Эрүүл мэндийн газар	93.6
15	Соёл, урлагийн газар	95.7
16	Биеийн тамир, спортын газар	87.5
17	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	95.0
18	Нийгмийн даатгалын хэлтэс	85.0
19	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	88.3
20	Боржигин чуулга	82.0
21	Боржигин өв музей	95.0
22	Нийтийн номын сан	95.0
23	Политехникийн коллеж	83.0
24	Насан туршийн боловсролын төв	85.0
25	Хүнс, хөдөө аж ахуйн газар	95.0
26	Мал эмнэлгийн газар	85.0
27	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	95.5
28	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	88.6
29	Орон нутгийн өмчийн газар	92.6
30	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	90.0
31	Ус-Ду ОНӨААТҮГ	90.0
32	Талын Илч ОНӨААТҮГ	80.0
33	Илчлэг Шивээ ОНӨААТҮГ	86.6
34	Сум дундын Ойн анги ОНТБ	86.6
35	Автотээврийн төв	80.0
36	Стандарт хэмжил зүйн хэлтэс	90.0
Дундаж хэрэгжилт, хувь		90.5

5.4. Хэрэглэгчийн үнэлгээ:

2023 оны үйл ажиллагааны үр дүнг иргэд, олон нийтээр үнэлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулан анкетын буюу санал асуулгын аргаар хэрэглэгчийн үнэлгээ хийлээ.

Хэрэглэгчийн үнэлгээний хүрээнд дараах сэтгэл ханамжийн судалгаануудыг боловсруулж, цахим хэлбэрээр авсан. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг иргэд, олон нийтээр үнэлүүлэх сэтгэл ханамжийн судалгаа
3. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, олон нийтээр үнэлүүлэх сэтгэл ханамжийн судалгаа

Судалгааг Google form системийг ашиглан авч, үр дүнг тооцсон. Судалгааний нэгдсэн дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 18. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн дүн

Судалгааны төрөл	Судалгаанд хамрагдсан хүний тоо	Судалгааны асуултын тоо	Дундаж үнэлгээ, хувь
Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа	42	23	90.0
Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг иргэд, олон нийтээр үнэлүүлэх сэтгэл ханамжийн судалгаа	54	18	77.8
Нийт	96	51	83.9



Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа, түүний үр дүн:

Тус судалгаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын 53 албан хаагчаас 42 албан хаагч хамрагдсан бөгөөд нийт албан хаагчдын 79.2 хувийг хамруулсан. Судалгааг төрийн албан хаагчдын сургалт, хөгжил, нийгмийн баталгаа хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах сэтгэл зүйн болон материалаг орчин нөхцөл бүрдсэн, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, ил тод, хурдан шуурхай хүргэх боломж бүрдсэн эсэхийг тогтоох зорилгоор санал асуулгын аргаар авсан.

Сэтгэл ханамжийн судалгааны хүрээнд 23 асуулгаар санал асуулга авч, үр дүнг нэгтгэж үзэхэд ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 90.0 хувьтай байна. Судалгааны дүнг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт.19. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн

№	Судалгааны асуулга	Сэтгэл ханамжийн түвшин, хувь
1	Таны гүйцэтгэж буй ажил үүрэг байгууллагын эрхэм зорилго, зорилтыг биелүүлэхэд хэр хувь нэмэр оруулж байна гэж үзэж байна вэ?	100
2	Таны ажил үүрэг тодорхой, ойлгомжтой байдаг уу?	93.2
3	Ажлаа хийж гүйцэтгэхэд шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан уу?	96.0
4	Байгууллагын ажиллах орчин, өрөө тасалгааны нөхцөл байдал ажиллах нөхцөл шаардлага бүрэн хангагдсан уу.	95.6
5	Байгууллагын ариун цэврийн өрөө болон цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг эсэх.	92.0
6	Та ажил дээрээ өөрийн ур чадвараа бүрэн дайчлан ажиллах боломжтой юу.	92.1
7	Таны сайн ажилласныг удирдлага, хамт олон тань үнэлж сайшааж магтдаг уу.	81.2
8	Таны удирдах ажилтан эсвэл хамт олон таныг хувь хүнийх нь хувьд анхаардаг уу. Сэтгэл санаагаар дэмжих, эрүүл мэндэд тань анхаарах гэх мэт ажлын бус асуудлаар/	80.9
9	Таны мэдлэг, ур чадвараа хөгжүүлэхэд байгууллагын зүгээс /удирдах ажилтан, ажлын хамт олон, бусад ажилтнууд анхаарч, дэмждэг үү.	92.1
10	Ажил үүрэгтэй холбоотойгоор дэвшүүлсэн таны санал санаачилгыг удирдах ажилтан болон хамт олон тань дэмждэг үү.	98.0
11	Удирдах ажилтан таны ажлын гүйцэтгэл, ахиц, дэвшлийн талаар тантай хэр ярилцдаг вэ?	90.5
12	Байгууллагын удирдах ажилтан бүх ажилтнуудтай шударга ханддаг уу?	80.0
13	Та ажил дээрээ өөрийн санал, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаг уу?	94.7
14	Ажилтнууд бие биедээ хүндэтгэлтэй ханддаг уу?	97.3
15	Танай байгууллагад багаар ажиллах соёл бүрдсэн үү?	83.6
16	Танай байгууллага ажилтнуудын ажил, амьдралын тэнцвэртэй байдлыг дэмждэг үү?	85.4
17	Би энэ байгууллагад ажилладгаараа үргэлж бахархдаг	95.2
18	Таны цалин, урамшуулал таны амьдралд хүрэлцэж байна уу?	71.1
19	Та цаашид энэ байгууллагадаа тогтвортой ажиллана гэж боддог уу?	76.4
20	Та байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэдэг үү?	82.3
21	Та байгууллагынхаа олон нийтийг хамарсан арга хэмжээнд тогтмол оролцдог уу?	87.4
22	Танай байгууллага таныг нийгмийн баталгааг хангаж чадаж байна уу?	92.3
23	Та ажлын цагийг хэр баримталдаг вэ?	100
Сэтгэл ханамжийн дундаж түвшин, хувь		90.0

Жич: Сэтгэл ханамжийн түвшинг маш сайн, сайн, хангалттай, тийм гэм мэт эерэг хариултын нийт санал асуулгад эзлэх хувиар тооцов.



Судалгааны дүнгээс харахад байгууллагын үндсэн үйл ажиллагаа явуулах боломж, иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чирэгдэлгүй, ил тод хүргэх орчин нөхцөл тодорхой хэмжээнд бүрдсэн байгаа нь харагдаж байна. (1-6, 20, 23 асуултын үнэлгээг үндэслэв)

Судалгааны дүнгээс төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай нь харагдаж байна. (9, 18, 19, 22 дугаар асуулгын дүнг үндэслэв)

Байгууллагын соёл, уур амьсгал, харилцаа хандлага, бие биенээ дэмжсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн дүнгээс тодорхой хэмжээнд эерэг үзүүлэлт үзүүлсэн боловч сайжруулах шаардлагатай нь харагдаж байна. (6-8, 10-15, 17, 19, 21 дэх асуулгын дүнг үндэслэв)

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд иргэд, олон нийтээс өгсөн үнэлгээ: Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг иргэд, олон нийтээр үнэлүүлэх санал асуулыг цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 56 иргэн санал өгсөн байна.

Санал асуулгын хүрээнд 18 асуулгын үр дүнг нэгтгэж, ерөнхий үнэлгээг тооцоход 77.6 хувьтай байна. Судалгааны дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт.20. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд иргэд, олон нийтээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн

№	Судалгааны асуулга	Сэтгэл ханамжийн түвшин, хувь
1	Албан хаагчдын харилцаа, хандлагыг үнэлнэ үү	86.4
2	Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг үнэлнэ үү	87.7
3	Та манай байгууллагаас өөрийн хүссэн үйлчилгээг авч чадсан уу.	83.2
4	Орон нутагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын үр дүнг үнэлнэ үү.	66.8
5	Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл иргэдэд хурдан шуурхай, хүртээмжтэй хүрдэг үү.	72.3
6	Аймгийн www.govisumber.gov.mn цахим хуудсаар үйлчлүүлж байсан бол үнэлгээ өгнө үү.	90.5
7	Байгууллагын үйл ажиллагаа, төсөв хөрөнгө, түүний зарцуулалтын талаар мэдээ, мэдээллийг ил тод нээлттэй авч чадаж байна уу?	75.3
8	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтот хөтөлбөр, арга хэмжээнд та хамрагдаж байсан бол үр дүнг үнэлнэ үү.	79.2
9	Аймгийн Засаг даргын Тамгын газрын нээлттэй утсаар үйлчлүүлж байсан бол үйлчилгээний чанарыг үнэлнэ үү.	71.5
10	Таны өргөдөл гомдол, санал хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэж өгч чадсан уу?	69.7
11	Аймгийн Засаг даргын Тамгын газар нь шударга ёсыг бэхжүүлэх авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэр үр дүнтэй ажиллаж байна гэж та үзэж байна вэ?	70.2
12	Сүүлийн 12 сарын хугацаанд та болон танай гэр бүлийн ойр дотны нөхдөөс чинь тухайн байгууллагын алба хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйл өгсөн явдал байсан уу?	65.3
13	Аймгийн Засаг даргын Тамгын газрын авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлийг та хэрхэн үнэлэх вэ?	71.5
14	Та аймгийн ногоон байгууламжийн эзлэх хувь өссөн гэж үзэж байна уу?	94.3
15	Манай аймгийн нутаг дэвсгэрт ил задгай хог хаягдал буурсан гэж та бодож байна уу?	57.2
16	e-mongolia цахим системээс үйлчилгээ авахад хүндрэлтэй байсан уу?	87.8
17	e-mongolia оператороор үйлчлүүлэхэд хүндрэлтэй байсан уу	90.5
18	Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд өгөх таны үнэлгээ	80.5
Сэтгэл ханамжийн дундаж түвшин, хувь		77.8



Жич: Сэтгэл ханамжийн түвшинг маш сайн, сайн, хангалттай, тийм гэм мэт эерэг хариултын нийт санал асуулгад эзлэх хувиар тооцов.

Сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Орон нутагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх, мэдээ мэдээллийг иргэдэд нээлттэй хүргэх.
2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд мэдээ мэдээллийг хүргэх.
3. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, нээлттэй утасны үйл ажиллагааг сайжруулах.
4. Авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулах, соён гэгээрүүлэх, сурталчлах арга хэмжээг идэвхжүүлэх, удирдлагын манлайлал, амлалтыг дээшлүүлэх.
5. Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилт, арга хэмжээг бодитой төлөвлөж, үр дүн, үр нөлөөг сайжруулах.

ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын дагуу үнэллээ.

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой “Ногоон байгууламж (мод тарих)” арга хэмжээний хэрэгжилт 86.6 хувьтай, “Цахим шилжилт” арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай, “Хог хаягдлын менежмент” арга хэмжээний хэрэгжилт 86.5 хувьтай, дундаж хэрэгжилт 89.3 хувьтай байна. Нэгдсэн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт.21. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжилтийн хувь
1	Ногоон байгууламж (мод тарих)	86.6
2	Хог хаягдлын менежмент	86.5
3	Цахим шилжилт	95.0
Дундаж хэрэгжилт		89.3

6.1. “Ногоон байгууламж (мод тарих)” арга хэмжээний хэрэгжилт:

“Ногоон байгууламж (мод тарих)” арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр “Аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөө”-нд 1 зорилтын 2 арга хэмжээг тусган батлуулж, зорилт, арга хэмжээг дунджаар 100 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд 8 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, дунджаар 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Үүнд:

- Иргэд, олон нийтийн оролцоог хангах, уриалах, идэвх санаачлагыг өрнүүлэх зорилгоор Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Бүх нийтээр мод тарих өдөр, тарьц суулгацын үзэсгэлэн худалдаа зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор 1241 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Үүний үр дүнд иргэдийн оролцоо 3 дахин нэмэгдэж, мод бут тарьж ургуулах, арчилгаа, тордолгоо хийх ажилд 80 аж ахуйн нэгж, байгууллагын 660 албан хаагч, 581 иргэн тус тус оролцсон.



- Иргэн аж ахуйн нэгжийн мод, бут тарьж ургуулах идэвх санаачлагыг дэмжих, мод, бут тарих ажлыг үр дүнтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Мод, бут, сөөг тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ын дагуу 2023 онд 26 иргэн, 1 аж ахуйн нэгжид нийт 32.2 сая.төгрөгийн урамшууллыг орон нутгийн төсвөөс олгосон байна.



- 2023 онд нийт талбайд 52474 мод бут тарьж Үүнээс: Сүмбэр сум 37101, Шивээговь сум 7000, Баянтал сум 8373 мод бут тус тус тарьсан бөгөөд төвийн ногоон байгууламжид 23066 мод, ойн зурваст 7630 мод, иргэн, аж ахуйн нэгжийн өмчлөл, эзэмшлийн газарт 21778 мод, бут тарьж ургуулж, 17 га талбайд ойн зурвас, ногоон байгууламж шинээр байгуулан, 69.5 га-д хүрсэн. Мөн 4 мод үржүүлгийн газарт 78000 ширхэг тарьц, суулгацын үр мөчрөөр тарилт хийсэн. Нийт модны ургалт, амьдралтын хувь 81.0 байгаас 75-аас дээш ургалттай 44602 ширхэг буюу нийт шинээр тарьсан модны 85 хувийг эзэлж байна.



- Аймгийн хэмжээнд хот суурин газрын нийтийн эдэлбэр газар 1964.27 га байгаагаас ногоон байгууламжийн зориулалтаар мод тарьсан 69.5 га буюу нийт эдэлбэр газрын 3.5 хувийг ногоон байгууламж эзэлж байна.

- 2023 онд улсын төсвөөс 15 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэгч санал ирүүлээгүйн улмаас 10 га талбайд мод тарих ажлыг эхлүүлж, 5 га талбайн төсөв буцаан татагдсан.

Дээрх арга хэмжээний үр дүнд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 3 шалгуур үзүүлэлтийг дунджаар 86.6 хувьтай хангасан гэж үнэллээ. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав.



Хүснэгт. 22. Ногоон байгууламж (Мод тарих) арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага	Мэдээлэл цуглуулах арга зүй	Хүрсэн түвшин	Үнэлгээ хувь
Нэг.Ногоон байгууламж (Мод тарих)									
1	2	3	4	5	6	7	8	9	
Шинээр тарьсан мод	Ширхэг	54521	80000	Үрээр болон тарьц, суулгацаар шинээр тарьж ургуулсан мод, сөөгний тоо	Жилд	БОАЖГ	Тайлан	52474	65.5
ургалтын хувь	Хувь	80	85	Тухайн жилд шинээр тарьсан модонд 75 хувиас дээш ургалттай модны эзлэх хувь	Жилд	БОАЖГ	Тайлан	85	100
Хот суурины эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь	Хувь	2.4	3.7	Тухайн хот суурингийн эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь	Жилд	ГХБХБГ / БОАЖГ	Газар зүйн мэдээллийн сан	3.5	94.5
Дундаж үнэлгээ, хувь									86.6

Цаашид ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэмэгдүүлэх, таригдсан модны ургалтын хувийг бууруулахгүй байх, тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагат

6.2. “Хог хаягдлын менежментийг сайжруулах” арга хэмжээний хэрэгжилт:

“Хог хаягдлын менежментийг сайжруулах ” арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр “Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө”-нд 2 зорилтын 7 арга хэмжээг тусган батлуулж, зорилт, арга хэмжээг дунджаар 80 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд 5 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, дунджаар 91,6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах үр дүнд хүрсэн.

Хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд нийт 2023 онд нийт 5 арга хэмжээ, 33 нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийг зарцуулсан. Үүнд:

- Хог хаягдлын менежментийг сайжруулж, ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд 3 дахивар авах цэгт 5 тн гялгар уут, 40100 шил, 9 тн хуванцар 350 кг гялгар уут, 500 кг цаас, 312 хаягдал зайг ангилан ялган, эдийн засгийн эргэлтэд орсонг хог хаягдлын хэмжээ 1.5 хувьд хүрсэн.
- Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт хог хаягдал шатаах утаагүй зуух суурилуулах ажилд аймгийн ОНХСанд 150.0 сая төгрөг тусгасан бөгөөд тус ажлын тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан боловч амжилтгүй болсон.



- Улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр суманд Ажнай Шарга ХХК “Аюултай хог хаягдлын түр агуулахын барилга”-ын ажлыг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгөх шатанд байна.
- Хог хаягдлаар бүтээл хийх уралдаанд 6 сургуулийн 100 гаруй хүүхэд оролцож, 6 сургуулийн 20 хүүхэд, 11 ангийг шалгаруулж, нийт 1,3 сая төгрөгөөр урамшуулсан.
- Барилгын туурь, хур хог хаягдалтай 190.8 га газар байгаагаас Сүмбэр сумын төвд барилгын туурь, хур хог хаягдалтай газрыг цэвэрлүүлэхээр Албанбулаг уул ХХК-тай гэрээ байгуулж, 31 цэгт 6500 тн барилгын болон хур хог хаягдлыг цэвэрлэн, БХНСАХЗ-аас 19.0 сая төгрөг зарцуулсан. Шивээговь сум 7.7 сая төгрөгийн хөрөнгөөр 3 га талбайн туурь хог хаягдлыг цэвэрлэсэн.
- Бүх нийтийн оролцоотой давхардсан тоогоор 67 байгууллага 332 удаагийн цэвэрлэгээг зохион байгуулсан бөгөөд аймгийн хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг давхардсан тоогоор 18 удаа зохион байгуулж 67 байгууллагын 1261 иргэн 210 тн хог хаягдлыг цэвэрлэсэн байна. Уст цэгийн цэвэрлэгээ 7 удаа зохион байгуулж, нийт 4.1 га талбайн 23 тонн ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг [Хоргүй Сүмбэр | Facebook](#) пэйж хуудсанд нийтлэсэн.

Дээрх арга хэмжээний үр дүнд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2 шалгуур үзүүлэлтийг дунджаар 86.5 хувьтай хангасан гэж үнэллээ. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 23. “Хог хаягдлын менежмент” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага	Мэдээлэл цуглуулах арга зүй	Хүрсэн түвшин	Үнэлгээ хувь
Хог хаягдлын менежмент									
1	2	3	4	5	6	7	8	9	
Хог хаягдлын эдийн засгийн эргэлт	Хувь	0	0.01	Тухайн жилд боловсруулсан хог хаягдлыг нийт хог хаягдлын хэмжээнд харьцуулж, хувиар илэрхийлнэ.	Жилд	БОАЖГ	Тайлан	0.01	100
Ил задгай хог хаягдалгүй байх	Оноо	0	70	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээр	Жилд	БОАЖГ	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа	51.1	73.0
Дундаж үнэлгээ, хувь									86.5

6.3. “Цахим шилжилт” арга хэмжээний хэрэгжилт:

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний хүрээнд 18 арга хэмжээг дунджаар 96.7 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.


Сайн засаглалыг бэхжүүлэх зорилтын хүрээнд “Цахим шилжилт” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:



- 2023 оны байдлаар 145 төрийн үйлчилгээ цахимжуулахаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 15 байгууллагын 61 төрийн үйлчилгээг e-mongolia программд холбон цахимжуулсан байна. 41.4%
- Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системийн ашиглалтыг өргөжүүлэх, аймаг, орон нутгийн иргэд, олон нийтэд төрийн цахим үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд Говьсүмбэр аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн байр болон “Хурдан” цэгүүдэд 53.0 сая төгрөг бүхий тавилга, тоног төхөөрөмжөөр ханган дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн Төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулах чиглэлээр сумд болон аймгийн хэмжээнд зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээнд оролцож буй 197 иргэдэд Төрийн цахим үйлчилгээг үзүүлэн, 535 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч, 500 иргэнээс төрийн цахим үйлчилгээний талаар судалгааг авч ажиллахад дэмжлэг үзүүлсэн. Судалгаанд хамрагдсан иргэдийн 80 хувь нь төрийн үйлчилгээ цахимжиж буйд сэтгэл хангалуун байсан.
- Huduu.mn платпормын 9 цэсэд аймгийн 28 байгууллагын 643 мэдээ, мэдээллийг оруулан 1182 иргэний хандалт авч 21 аймгаас 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. байна.
- Говьсүмбэр аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн Цахим хуудсанд 71 мэдээ, мэдээлэл, 10 шторк бичлэг бэлтгэн нийтэлж, холбогдох бусад байгууллагуудын 386 мэдээ мэдээллийг түгээж нийт 5495 хүн хандалт өгөөд байна. Нийт давхардсан тоогоор 54000 иргэнд цахимаар мэдээлэл хүргэсэн байна.
- Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар төрийн цахим үйлчилгээг операторын горимоор 55 төрлийн 4277 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлсэн байна.
- Аймгийн Засаг даргын Тамгын газар иргэдийн санал хүсэлтийг аймгийн албан ёсны цахим хуудас www.govisumber.gov.mn цахим сайтаар болон 70543434 утас, 11-11 төвөөр хүлээн авч шийдвэрлэж байна. Жилийн эцсийн байдлаар биеэр 394, 70543434 дугаар утсанд 6 өргөдөл, цахимаар 1 өргөдөл ирснийг 100 хувь шийдвэрлэсэн. 11-11 төвөөр нийт 36, албан бичгээр 39 нийт 476 өргөдөл хүлээн авсанаас төрлөөр нь авч үзвэл 28 гомдол, 448 хүсэлт ирсэн байна. 116 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн нь нийт өргөдлийн 24,3 хувийг, 54 өргөдлийг хуулийн хүрээнд судлан шийдвэрлэх боломжгүй талаар хариу хүргүүлсэн нь нийт өргөдлийн 11.7 хувийг тус тус эзэлж байна.
- Аймаг, сумын Засаг даргаас олгодог нийт 15 тусгай зөвшөөрлийг цахимжуулан e-mongolia цахим системд холбосон. 2023 онд тусгай зөвшөөрөл хүссэн 2 төрлийн 18 хүсэлтээс 18 хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн шийдвэрлэлт 100 хувьтай байна.
- Цахимаар хүлээн авч, шийдвэрлэж байгаа тусгай зөвшөөрлийн тоо – 18, Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байгаа байгууллагын тоо – 24, Цахим болон нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь-100
- Аймгийн Засаг даргын харьяа 21 агентлаг, 3 суманд төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP нэвтрүүлж нийт 56 байгууллага ERP систем нэвтрүүлэн 509 төрийн албан хаагч холбогдож, төрийн байгууллагын мэдээллийг дотоод удирдлагын системээр солилцох үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- 2023 онд Говьсүмбэр аймгийн хэмжээнд 16-аас дээш буюу насанд хүрсэн 11779 иргэд байгаагаас E-Mongolia цахим системд 9395 иргэн бүртгүүлэн 246.433 хүсэлт илгээж нийт насанд хүрсэн хүн амын 79.7 хувь нь E-Mongolia Цахим системээр үйлчилгээ авсан байна.
- Говьсүмбэр аймгийн хэмжээнд үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчийн тоо 20798, суурин интернэт хэрэглэгчийн тоо 2457 байна.
- Говьсүмбэр аймгийн 3 сум шилэн кабелд холбогдсон 10 баг үүрэн холбооны хөдөлгөөнт сүлжээнд холбогдсон байна.



Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас гаргасан аймгуудын цахим шилжилтийн тайлангаас Говьсүмбэр аймгийн цахим шилжилтийн бэлэн байдлын үнэлгээ авч үзлээ.



Аймгуудын цахим шилжилтийн бэлэн байдлын ерөнхий үнэлгээгээр Говьсүмбэр аймаг 25 онооноос 15.6 оноо авч аймгуудын дунджаас дээгүүр 6 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Үүнээс удирдлага, манлайлал 6 дугаарт, хандлага 3 дугаарт, ур чадварын түвшин 3 дугаарт, дэд бүтэц 7 дугаарт, инноваци 6 дугаарт тус тус байгаа нь дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цахим шилжилтийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр хавсралтын дагуу үнэлэхэд Орон нутгийн цахим үйлчилгээний индекс 1, иргэдийн цахим оролцооны индекс 1, Дотоод үйл ажиллагааны удирдлагын системийн нэвтрүүлэлтийн индекс 0.9, “e-mongolia” цахим үйлчилгээний хамрагдалтын индекс 0.9 буюу цахим шилжилтийн индекс 0.95 буюу “Цахим шилжилт” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг 2023 онд 95.0 хувьтай хангасан байна. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 24. “Цахим шилжилт” арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хангалт

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага	Мэдээлэл цуглуулах арга зүй	Хүрсэн түвшин	Үнэлгээ хувь
Цахим шилжилт									
1	2	3	4	5	6	7	8	9	
Орон нутгийн цахим үйлчилгээний индекс	индекс	1	1	НҮБ-ын цахим засаглалын хөгжлийн индекс тодорхойлдог аргачлал болон "E-Mongolia" цахим үйлчилгээний систем	Жилд	АЗДТГ СЗДТГ	Судалгаа, "e-mongolia" цахим системийн тайлан	1	100
Иргэдийн цахим оролцооны индекс	индекс	1	1	Шийдвэр гаргалт, хөрөнгө оруулалтад санал болон өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр авч буй байдал	Жилд	АЗДТГ СЗДТГ	Судалгаа 1111 төвийн мэдээллийн системийн тайлан	1	100
Дотоод үйл ажиллагааны удирдлагын систем нэвтрүүлэлт	Хувь	86.0	100	Дотоод удирдлагын систем ашиглаж буй орон нутгийн төрийн байгууллагуудын тоо	Жилд	АЗДТГ СЗДТГ	Тайлан	90	90
"E-Mongolia" цахим үйлчилгээний	Хувь	66.0	100	"E-Mongolia" цахим үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог	Жилд	АЗДТГ СЗДТГ	Судалгаа, тайлан	90	90



хамрагдал Т				тухайн орон нутгийн насанд хүрсэн иргэдийн тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ.						
Дундаж үнэлгээ, хувь										95

Цахим шилжилтийн индексийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас баталсан “Шалгуур үзүүлэлтийг үнэлэх аргачлал”-ын дагуу тооцож, үр дүнг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт.25. Цахим шилжилтийн индекс (2023 оны жилийн эцэс)

Үзүүлэлт	Агуулга	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Агуулгын үнэлгээ	Тооцох аргачлал		Нийлбэр огноо (лавлах оноо=50)		
						8	9	10	11	12
Орон нутгийн цахим үйлчилгээний индекс (ОНЦҮИ)	1.Тухайн жил цахимжуулсан төрийн үйлчилгээний тоо, хувиар	457	145 100%	61 100%	10%<1 10%>0	ОНЦҮ И= Үнэлгэ э(1+2+3+4+5+6+7+8)/8	ЦАХИМ ШИЛЖИЛТ =(ОНЦҮ И+ИЦОИ + ДҮАУСН + ЦҮХ)/4*100	1	ОНЦҮИ=1	ЦАХИМ ШИЛЖИЛТ =(1+1+0.86+1)/4*100= 95.0 %
	2.Төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх портал,апплик ейшнийг хөгжүүлж, нэвтрүүлсэн эсэх	-	100%	100%	Тийм = 1 Үгүй = 0		100-90%=15, 89-80%=12, 79-70%=9, 69-60%=6, 59-50%=3, 49%<0	1		
	2.2 Төрийн үйлчилгээний цахим портал(URL)	26	100%	Тийм				1		
	3.Тухайн жил цахим хэлбэрээр төрийн үйлчилгээг авсан иргэдийн тоо	9220	4000 100%	5559 100%	1000<1 1000>0			1		
	4. Иргэдэд цахим үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хүргэж,сурталчлах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	15	15	15	2<1 2>0			1		
	5.Нийт иргэдийн дунд тоон бичиг үсгийн хэрэглээг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	3	8	3	1<1 0=0			1		
	6.Нийт төрийн албан хаагчдын дунд тоон бичиг үсгийн хэрэглээг	2	2	2	1<1 0=0			1		



	сайжруулах чиглэлээр арга хэмжээний тоо											
	7.Аймгийн төвийн өндөр хурдны өргөн зурвасын сүлжээний холболт	8	100%	100%	10гбит/сек <1 10гбит/сек >1			1				
	8.Өргөн зурвасын интернэтэд холбогдсон өрхийн нэвтрэлтийн түвшин	4000	100%	82%	50%<1 50%>0			1				
Иргэдийн цахим оролцооны индекс (ИЦОИ)	1.Нийт санал ,хүсэлт , өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэсэн байдал, хувиар	29	50%	476 100%	50%<1 50%>0	НЦОИ =Үнэл гээ(1+ 2+3+4 +5)/5		1				
	2.Шийдвэр гаргалтанд иргэдийн саналыг хүлээн аван тоо, хувиар (нийт шийдвэр гаргалтанд иргэдээс авсан санал хүсэлтийн авахдаа цахим хэлбэрээр авсан байдал)	29	50%	100%	50%<1 50%>0			1				
	3.Албан ёсны цахим хуудсанд төрийн үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг иргэд, аж ахуй нэгжээс авдаг эсэх	Тийм	Тийм	Тийм	Тийм = 1 Үгүй = 0			1		ИЦО И= 1		
	4.Төрийн үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	-	-	1<=1 0=0			1				
	5.Аймгийн албан ёсны цахим хуудсыг тогтмол шинэчлэн, иргэдэд мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэдэг эсэх	Тийм	Тийм	Тийм	Тийм = 1 Үгүй = 0			1				



Дотоод үйл ажиллагааны удирлагын систем нэвтрүүлэлт (ДҮАУСН)	1.Нийт албан бичгээс цахимаар солилцсон албан бичгийн тоо, хувиар	626	50%	1276 100%	50%<1 50%>0	ДҮАУ СН= Үнэлгэ э(1+2+ 3+4+5 +6+7)/ 7			1	ДҮА УСН =0.86	
	2.Нийт нутгийн захиргааны байгууллагуудын дотоод систем холбосон тоо, хувиар	45	60 80%	56 90%	80%<1 80%>0						1
	3.Нийт албан хаагчдын мэдээллийг цахимжуулсан байдал, хувиар (Хүний нөөцийн мэдээлэл)	53 100%	53 80%	53 100%	80%<1 80%>0						1
	4.Дотоод системийг ашиглан нийт албан хаагчдад мэдээ, мэдээлэл хүргэсэн тоо,хувиар	100%	50%	90%	50%<1 50%>0						1
	5.Нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн технологийн ажилчдыг мэргэшүүлэх чиглэлээр сургалтанд хамруулсан тоо	2	2	2	1<1 0=0						1
	6.Тоон гарын үсэгтэй албан хаагчдын тоо, хувиар	41	26 53 100% 50%	6 11.3% 110 80%	50%<1 50%>0						0
	7.Байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг нэврүүлсэн эсэх (албан бичиг боловсруулалт, шилжүүлэх г.м)	Тийм	Тийм	Тийм үгүй	Тийм = 1 Үгүй = 0						1
E- Mongolia цахим үйлчилгээ	1.Нутгийн захиргааны байгууллагуудын үйлчилгээ цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-д холбосон тоо,хувиар	61	145 100%	61 100%	10%<1 10%>0	ЦҮХ=Ү нэлгээ			1	ЦҮХ= 1	
	2.Төрийн үйлчилгээний	890	1000	5559	1000<1 1000>0				1		



ний хамрагдалт (ЦҮХ)	нэгдсэн төвөөр дамжуулан операторын горимоор үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээний тоо,(ЗГ-ын 2019 оны 149 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх шаардлагатай ,аймаг нийслэлийн төвд байрлах үйлчилгээний төвүүдэд операторын горимоор үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн, ЗДТГ-ын ажилтнуудад сургалт орсон, operator.emongolia.mn системийг суурилуулсан)					(1+2+3+)/3				
	3.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монголиар үзүүлсэн үйлчилгээний тоо	9220	8000 100%	246433 100%	50%<1 50%>0			1		

Дээрх хүснэгтээс харахад цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Аймаг, сумдын операторын системийн үйл ажиллагааг жигд хангаж, жилд 3000-аас доошгүй иргэнд үйлчилгээ үзүүлсэн байх.
2. Төрийн үйлчилгээний “e-mongolia” нэгдсэн системд төрийн үйлчилгээг нэмж холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.



ДОЛОО. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын дагуу нэгтгэж, дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт. 26. Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны үнэлгээ (2023 он)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	96.83	0.5	0.46
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	94.12		
	3.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	90.32		
	4.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	90.61		
	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	91.81		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	94.7	0.15	0.14
	2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	90.5		
	3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	98.6		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдал	98.67	0.2	0.18
	2.Шилэн дансны хөтлөлт	96.0		
	3.Шударга байдлын түвшин	90.5		
	4.Хэрэглэгчийн үнэлгээ	83.9		
Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	89.3	0.15	0.13
Ерөнхий үнэлгээ		91.0	1.0	0.91

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий үнэлгээгээр Аймгийн Засаг даргын Тамгын газрын жилийн үйл ажиллагаа 91.0 хувьтай (0.91 оноо) үнэлэгдэж байгаа нь өмнөх оноос гүйцэтгэлийн үр дүн буураагүй, өмнөх оны түвшинд байгааг харуулж байгаа бөгөөд үнэлгээнээс бодлогын үр дүн, үр нөлөө дээшилсэн байгаа нь харагдаж байна.



Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, удирдлага, арга зүйгээр ханган, төрийн үйлчилгээг нээлттэй, ил тод, чанар, хүртээмжтэй хүргэн ажилласны үр дүнд хэрэглэгчийн сэтгэл ханамж өсч 83.9 хувьд хүрсэн бөгөөд Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс гаргасан “Аймгуудын 2022 оны өрсөлдөх чадварын үнэлгээ”-ээр 82.79 оноогоор улсын хэмжээнд 5 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлсийг авч үзвэл засаглалын үр ашиг 92.95 оноогоор 2 дугаарт, дэд бүтэц 89.61 оноогоор 3 дугаарт, бизнесийн үр ашиг 57.18 оноогоор 10 дугаарт, эдийн засгийн тамир тэнхээ 41.66 оноогоор 13 дугаарт тус тус эрэмбэлэгдсэн байна.






График.17. Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ

ЭДИЙН ЗАСГИЙН ТАМИР ТЭНХЭЭ



ЗАСАГЛАЛЫН ҮР АШИГ





БИЗНЕСИЙН ҮР АШИГ

ДЭД БҮТЭЦ






График.18. Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлсийн үнэлгээ



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан-2022

График.19. Өрсөлдөх чадварын төлөв байдлын үнэлгээ



Өрсөлдөх чадварын төлөв байдлыг авч үзвэл аймгийн төсөв, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны үзүүлэлт 1 дүгээрт, бизнесийн эрх зүй, нийгмийн тогтолцоо, санхүү 2 дугаарт, институцийн тогтолцоо, үндсэн дэд бүтэц 3 дугаарт, хүн амын амьжиргааны түвшин, менежментийн хэвшил 5 дугаарт тус тус эрэмбэлэгдэж байгаа бол эдийн засгийн салбарууд 20, хөдөлмөрийн зах зээл, бүтээмж 19 дүгээрт эрэмбэлэгдэж байна.

Иймээс цаашид эдийн засгийн салбаруудыг дэмжин хөгжүүлэх, эдийн засгийн хүчин чадал, хөдөлмөрийн зах зээлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, мэдээлэл технологийн дэд бүтцийг сайжруулж, боловсрол, соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Мөн төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийг тэлэх, бүс, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах төсөл, хөтөлбөрийг дэмжин ажиллах, орон нутгийн бодит нөөцөд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой.

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг бодлогын зорилттой уялдуулан бодитой төлөвлөж, үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай.

Тайлан хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

М.Анхбаяр

Тайлан нэгтгэсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

О.Болормаа

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхзаяа